



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэр боловсруулах журам,  
аргачлалыг батлах тухай

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.8.9 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. “Шүүхийн шийдвэр боловсруулах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх (цагаатгах) тогтоол боловсруулах аргачлал”-ыг 2 дугаар хавсралтаар, “Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал боловсруулах аргачлал”-ыг 3 дугаар хавсралтаар, “Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоол боловсруулах аргачлал”-ыг 4 дүгээр хавсралтаар, “Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал”-ыг 5 дугаар хавсралтаар, “Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал боловсруулах аргачлал”-ыг 6 дугаар хавсралтаар, “Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол боловсруулах аргачлал”-ыг 7 дугаар хавсралтаар, “Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал”-ыг 8 дугаар хавсралтаар, “Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал боловсруулах аргачлал”-ыг 9 дүгээр хавсралтаар, “Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол боловсруулах аргачлал”-ыг 10 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журам, аргачлалыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн бүх шатны шүүхүүд дагаж мөрдсүгэй.

3. Журам, аргачлалыг бүх шатны шүүхүүдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Улсын дээд шүүхийн Тамгын газар (С.Амардэлгэр)-т даалгасугай.

4. Энэ журам, аргачлалыг хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан Улсын дээд шүүхийн 2006 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 21 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН  
ТАНХИМЫН ТЭРГҮҮН

ИРГЭНИЙ ХЭРГИЙН  
ТАНХИМЫН ТЭРГҮҮН

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН  
ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Д.ГАНЗОРИГ


Ч.ХОСБАЯР

Г.АЛТАНЧИМЭГ

Ч.ТУНГАЛАГ

050109

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны  
2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн  
29 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



## ШҮҮХИЙН ШИЙДВЭР БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Журмын зорилго нь хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд бүх шатны шүүхээс гарч буй аливаа шийдвэрийг хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцүүлэх, шүүхийн шийдвэрийн талаар Монгол Улсын шүүхийн тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудад туссан зохицуулалтыг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх явдлыг хангахад оршино.

### Хоёр. Шүүхийн шийдвэрт тавигдах шаардлага

2.1. Шүүхийн шийдвэр нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. Шүүхийн шийдвэр "хууль ёсны байх" шаардлагыг хангахын тулд шүүх хэрэг, маргааны талаар материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээг тэдгээрийн агуулга, зорилгод нийцүүлэн, хуулийн урьдчилсан нөхцөл бодит байдалд бүрдсэн эсэхэд дүгнэлт хийсний үндсэн дээр оновчтой, зөв тайлбарлан хэрэглэнэ.

2.1.2. Шүүх нь хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр бусад хууль, Монгол Улсын соёрхон баталж, нэгдэн орсон олон улсын гэрээг хэрэглэхээс гадна олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг хэрэглэж болно.

2.1.3. Шүүх Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй хууль, олон улсын гэрээг хэрэглэхгүй бөгөөд хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Монгол Улсын Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзвэл хуульд заасан журмын дагуу саналаа Улсын дээд шүүхэд гаргана.

2.1.4. Тухайн харилцааг зохицуулсан хуулийн зүйл, заалт хоорондоо зөрчилтэй байвал шүүх нарийвчилсан зохицуулалттай хэм хэмжээг буюу хэрэг маргааны үйл баримтаар тодорхойлогдож буй харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг хэрэглэнэ.

2.1.5. Иргэний эрх зүйн маргаантай харилцааг зохицуулсан тухайлсан хууль байхгүй бол шүүх төсөөтэй харилцааг зохицуулж байгаа хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ. Хэрэв тийм хууль байхгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн агуулга, ерөнхий үндэслэл, үзэл санаанд нийцүүлэн шийдвэрлэнэ.

2.1.6. Захиргааны эрх зүйн маргаантай харилцааг зохицуулсан тухайлсан хууль байхгүй бол ерөнхийлөн зохицуулсан хуулийг, хэрэв тийм хууль байхгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн агуулга, ерөнхий үндэслэл, үзэл санаанд нийцүүлэн шийдвэрлэнэ. Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн харилцааг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ.

2.1.7. Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ.

2.1.8. Эрүүгийн болон зөрчлийн эрх зүйн харилцаанд хуулийг төсөөтэй хэрэглэхгүй.

2.1.9. Тухайн маргаантай харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ байхгүй, эсхүл байгаа нь тодорхой бус, түүнчлэн хуулийн зүйл, заалт хоорондоо зөрчилтэй, шударга ёсонд, эсхүл нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцэхгүй байна гэсэн үндэслэлээр шүүх хүчин төгөлдөр хуулийн хэм хэмжээг хэрэглэхээс, хэргийг шийдвэрлэхээс татгалзаж болохгүй.

2.1.10. Хэрэг, маргааныг шийдвэрлэж буй шүүх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг хуулийн зүйл, заалтыг оновчтой зөв тайлбарлан хэрэглэхэд (үндэслэх хэсэгт) ашиглах ба харин тэрхүү тайлбарыг хэрэг, маргааны талаар шийдвэр гаргах үндэслэл болгож баримтлахгүй.

2.2. Шүүхийн шийдвэр “үндэслэл бүхий байх” хуулийн шаардлагыг хангахын тулд шүүх хэрэгт хамааралтай бөгөөд хуульд заасан арга хэрэгслээр олж авсан нотлох баримтаар хэргийн үйл баримт, ач холбогдол бүхий бүх нөхцөл байдал бүрэн тогтоогдсон, шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, шинжлэн судлагдсан нотлох баримтуудыг тал бүрээс нь бүрэн, бодитойгоор харьцуулан үзсэний үндсэн дээр хууль зүйн дүгнэлт өгнө.

2.2.1. Шүүхийн шийдвэрийн үндэслэл болж буй нотлох баримтууд нь хэрэгт хамааралтай буюу нэхэмжлэлийн шаардлага болон түүнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа татгалзлыг, эрүүгийн гэмт хэргийн үйл баримт, гэмт хэргийн сэдэлт, санаа зорилго, шүүгдэгчийн гэм буруугийн хэлбэр, хэмжээ, эрүүгийн хариуцлага оногдуулахад нөлөөлөх нөхцөл байдал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн хэмжээ, гэмт хэрэг үйлдэгдэх болсон шалтгаан, нөхцөлийг тогтооход ач холбогдолтой бөгөөд хэргийн үйл баримттай шалтгаант холбоотой байх ёстой.

2.2.2. Хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтууд нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тус тус заасан журмын дагуу хуулиар зөвшөөрөгдсөн арга хэрэгсэл, хэлбэрээр гаргасан, цугларсан, бүрдсэн тохиолдолд шүүхийн шийдвэрийн үндэслэл болох боломжтой болно. Хуулиар зөвшөөрөгдөөгүй арга хэрэгслээр олж авсан, хуульд заасан хэлбэрээр бэхжүүлэгдээгүй, үнэлэгдээгүй баримтыг шүүх нотлох баримт гэж үзэхгүй, шийдвэрийн үндэслэл болгож болохгүй.

2.2.3. Дахин нотлох шаардлагагүй баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болж болно. Энэ нь “нэгэнт шүүхээр тогтоогдсон байдаг тул урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тооцогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй” гэсэн зарчимд харшлахгүй.

2.2.3.1. Нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй. Нийтэд илэрхий үйл баримт гэдэг нь шүүхэд болон хэргийн оролцогчдод мэдэгдсэн байхаас гадна тухайн үйл баримтын талаар мэдээлэлтэй байх боломжтой тодорхой хүрээний хүмүүс мэдсэн, үйл баримтын талаар маргах боломжгүй байхыг хэлнэ.

2.2.3.2. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримтыг өөр хэрэгт дахин нотлох шаардлагагүй. Нэгэн тогтоогдсон үйл баримт гэдэгт шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт заасан болон уг хэсгийн үндэслэл болсон

шийдвэрийн “үндэслэх” буюу “хянавал” хэсэгт дүгнэгдсэн хоорондоо уялдаа холбоо бүхий үйл баримтыг ойлгоно.

а. Хүчин төгөлдөр болсон эрүүгийн хэргийн шийтгэх болон цагаатгах тогтоолын гэмт хэрэг гарсан эсэх, холбогдох этгээд гэм буруутай эсэхийг дүгнэсэн, шийдвэрлэсэн хэсэг нь иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэж буй шүүхэд дахин нотлох шаардлагагүй зүйлд хамаарна. Эрүүгийн хэргээс үүдэн гарсан нэхэмжлэлтэй иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчийн гэм буруугийн асуудлыг шүүх хянан хэлэлцэхгүй ба харин учирсан хохирол нь тухайн гэм буруутай үйлдэлтэй шалтгаант холбоотой эсэх болон хэмжээний асуудлыг хэлэлцэнэ.

б. Иргэний болон захиргааны хэргийн талаар гаргасан хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримтыг иргэний болон захиргааны өөр хэргийг шийдвэрлэхэд нотлогдсон гэж тооцно. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй этгээдийн хувьд хүчин төгөлдөр шийдвэрээр нотлогдсон үйл баримтын талаар өөр хэрэгт маргах эрх нь нээлттэй ба шүүх тухайн хэрэгт цугларсан баримтыг хянан хэлэлцэж, шийдвэр гаргана.

в. Арбитрын хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт нотлогдсон үйл баримтыг тухайн этгээдүүдийн оролцоотой иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахин нотлохгүй.

г. Иргэний болон захиргааны хэргийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон иргэний болон захиргааны эрх зүйн харилцаатай холбоотой үйл баримтыг эрүүгийн хэрэгт дахин нотлох шаардлагагүй.

2.2.4. Шинжээчийн дүгнэлт нь бусад нотлох баримттай адил хүчин чадалтай ба шүүх хэрэгт цугларсан бусад нотлох баримттай харьцуулан үзсэний үндсэн дээр үнэлнэ. Шинжээчийн дүгнэлт бусад нотлох баримтаар давхар нотлогдоогүй, тэдгээрээр үгүйсгэгдэж байгаа тохиолдолд түүнийг нотолгооны бусад хэрэгслээс илүүд авч үзэхгүй. Шинжээчийн дүгнэлтийн талаарх шүүхийн дүгнэлт бүхий үнэлгээ шийдвэрт бүрэн тусгагдсан байх ёстой. Шүүх шинжээчийн дүгнэлтийг баримтлахгүй байгаа шалтгаанаа шийдвэртээ дурдвал зохино. Ингэхдээ шинжээчийн дүгнэлт юунд тулгуурласан, шинжилгээнд гаргаж өгсөн бүх баримт судлагдсан эсэх, шүүхээс тавигдсан асуулт бүрт хариу өгөгдсөн эсэхийг шүүх дүгнэлтдээ тусгасан байвал зохино.

2.2.5. Хэрэгт авагдаагүй нотлох баримтыг үнэлэхгүй, шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.

2.2.6. Шүүхийн шийдвэрийн үндэслэл болж буй нотлох баримт шүүх хуралдаанаар заавал хянан хэлэлцэгдсэн байна. Хэрэгт авагдсан боловч шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдээгүй нотлох баримт шийдвэрийн үндэслэл болсон байвал шүүхийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөнд тооцно.

2.2.7. Эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах нууц ажиллагаа хийгдсэн бол гагцхүү тухайн ажиллагааны үр дүнг магадалгаа хэлбэрээр баримтат мэдээлэлд бэхжүүлэн хэрэгт хавсаргасан тохиолдолд хянан хэлэлцэж дүгнэлт хийх бөгөөд хэрэгт хавсаргаагүй тухайн ажиллагаатай холбоотой ямар ч баримтат мэдээллийг шүүх хуралдаанаар хэлэлцэх, шийдвэрийн үндэслэл болгохыг хориглоно.

Гурав. Шүүхийн шийдвэрт тавигдах бусад шаардлага

3.1. Иргэний болон захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох гэсэн дөрвөн хэсгээс бүрдэнэ. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн

шүүхийн шийдвэр нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар удиртгал, тодорхойлох, тогтоох хэсгээс бүрдэнэ.

3.2.Хэсэг болгоны нэрийг шинэ мөрний голд том үсгээр бичнэ (жишээ нь, ТОДОРХОЙЛОХ нь:, ҮНДЭСЛЭХ нь:, ТОГТООХ нь: гэх мэт). Шүүхийн шийдвэрийг холбогдох аргачлалын дагуу боловсруулна.

3.3.Шүүхийн шийдвэр нь хуулиар тогтоосон хэлбэр, бүтэц, дарааллын дагуу үйлдэгдсэн, шийдвэрлэж байгаа асуудлын агуулга, утга санааг бүрэн зөв, товч, тодорхой илэрхийлсэн, логик дэс дараалалтай, хууль зүйн үг хэллэг ашигласан, эрх зүйн онол, мэдлэгийн түвшинд бичигдсэн, үг, үсгийн болон зөв бичих дүрэм, найруулга зүйн алдаагүй, засваргүй бичигдсэн байна.

3.4.Шийдвэрт тодорхой бус томъёолол, албан баримт бичиг үйлдэхэд хэрэглэдэггүй үг, товчлол ашиглах, түүнчлэн хэрэгт ач холбогдолгүй үйл явдлыг тоочиж бичихийг хориглоно. Оноосон нэрийг буюу улс, хотын нэр, газар нутгийн нэр, байгууллагын нэр, хүний нэрийг бүтэн бичнэ. Хэрэв хэрэг, маргаанд хамааралтай зайлшгүй тусгагдах тусгай нэр томъёо, үг хэллэг хэрэглэсэн бол түүнийгээ тайлбарласан байна. Харин хууль зүйн шинжлэх ухаанд нийтлэг хэрэглэгддэг латин нэр томъёог ("pacta sunt servanda" гэх мэт) кирилл үсгээр галиглахгүй, орчуулахгүй, тайлбарлахгүйгээр бичиж болно.

3.5.Шүүхийн шийдвэрт хуулийн холбогдох зүйл, заалтыг хэрэглэхдээ хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтыг дэлгэрэнгүй бичих ба хуулийн зохицуулалтыг (текстийг) хашилтад хийнэ. Жишээ нь: Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1."Шүүгчид дараах зүйлийг хориглоно:", 50.1.2."албан үүрэгтэй нь холбоотой, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн нууцыг задруулах" гэх мэт.

3.6.Шүүхийн шийдвэрийг бичихдээ баримт бичгийн стандартад нийцүүлж Word программыг ашиглан Arial фонтын 11-12 хэмжээтэй үсгээр А4 хуудсан дээр мөр хоорондын зай 1.0, бичвэрийн талбай нь цаасны зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм, дээд захаас 20 мм, доод захаас 20 мм-ээс доошгүй байна. Цаасны хэмжээ А4 буюу 210x297 мм байна. Баримт бичгийн тэргүүг бичвэрээс мөр хоорондын зайг 2.0 мм, гарын үсгийг бичвэрээс 3.0-5.0 мм-ээр авна. Шийдвэрийг цаасны нэг талд хэвлэнэ. Шийдвэрийн дугаар программаас олгогдоно.

3.7.Шүүхийн шийдвэрийн эхний нүүрийг төрийн сүлд, шүүхийн нэр, баримт бичгийн нэр буюу шүүхийн шийдвэр (шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж), огноо, дугаар, үйлдсэн газрын нэрийг хөх өнгөөр хэвлэсэн хэвлэмэл хуудсан дээр үйлдэнэ. Шүүхийн шийдвэрийн хэвлэмэл хуудас нь баруун доод өнцөгт доод захаасаа 10 мм, баруун захаасаа 15 мм зай авч хөх өнгийн бэх бүхий тусгай дугаарлагчаар дугаарлагдсан байна, шийдвэрийн 2 дахь хуудаснаас араб тоогоор дугаарлана, дугаарыг хуудасны дээд захаас 10 мм зайд голлуулан байрлуулна.

3.8.Шийдвэрт эрх зүйн онолын ойлголт болон бусад хууль зүйн баримт бичгийн бичвэр, томъёоллыг бүхэлд нь, эсхүл давхардуулан тусгахгүй үүднээс эш татах нь зохимжтой гэж үзсэн бол эшлэлийг хийж, албан эх сурвалжийг заана. Шүүхийн шийдвэрт эшлэлийг дараах байдлаар хийнэ. Үүнд:

а.иргэн болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг эшлэхэд: нэхэмжлэгчийн нэр ба хариуцагчийн нэр (Italic-аар), хэргийн индекс, шүүхийн нэр, (танхимтай бол танхимын нэр), шийдвэрийн дугаар, хуудасны дугаар, мөрийн дугаарыг заана. Жишээ нь: *Б.Бат ба Татварын ерөнхий газар*, 125/2020/0005/з, УДШ, (Захиргааны хэргийн танхим), 001/ХТ2021/0043, х.5, мөр 4.; *Бат ХХК ба О.Баяр*, 101/2019/00468/и, УДШ (Иргэний хэргийн танхим), 001/ХТ2021/00025, х.10, м.3.

б.эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг эшлэхэд: шүүгдэгчийн нэр (Italic-аар), хэргийн дугаар, шүүхийн нэр, (танхимтай бол танхимын нэр), тогтоол, магадлалын дугаар, хуудасны дугаар, мөрийн дугаарыг заана. Жишээ нь: *Б.Батад холбогдох 1805044151400* эрүүгийн хэрэг, УДШ, (Эрүүгийн хэргийн танхим), 1хх, х.5, мөр 205.

в.Улсын дээд шүүхийн тайлбарыг эшлэхэд: шүүхийн нэр, тайлбарын нэр (Italic-аар), огноо, тогтоолын дугаар, хуудасны дугаар, мөрийн дугаарыг заана. Жишээ нь: УДШ, *Төрийн албаны тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай*, 2010, тогтоол №08, х.2, мөр 10.

г.хууль зүйн шинжлэх ухааны тайлбар, бусад онолын бүтээлийг эшлэхэд: зохиогчийн нэр (эрхлэн гаргагч), номын нэр (Italic-аар), хэвлэлтийн дугаар, хуудасны дугаар, хэвлэсэн он (хэвлэгдсэн оныг хаалтад бичнэ)-ыг заана. Жишээ нь: УДШ, *Иргэний хуулийн тайлбар*, 2.хэвлэл, (2015), х.200.; Б.Бат, *Захиргааны эрх зүй*, 1.хэвлэл, х.50, (2020).

д.эрдэм шинжилгээний өгүүллийг эшлэхэд: зохиогчийн нэр, өгүүллийн нэр (Italic-аар), хэвлэгдсэн сэтгүүлийн нэр, цувралын дугаар, хуудасны дугаар, хэвлэсэн он (хэвлэгдсэн оныг хаалтад бичнэ)-ыг заана. Жишээ нь: Б.Бат, *Хууль ёсны итгэл хамгаалах зарчим*, Эрх зүй, 01, х.20 (2021).

3.9.Шүүхийн шийдвэрт эшлэл болгосон шүүхийн шийдвэр, Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар болон хууль зүйн шинжлэх ухааны бүтээл нь хуулийн зүйл, заалтыг оновчтой зөв тайлбарлан хэрэглэхэд ашиглагдах ба харин тэдгээрийг хэрэг, маргааны талаар шийдвэр гаргах үндэслэл болгож, тогтоох хэсэгт баримтлахгүй.

3.10.Шүүхийн шийдвэрт нотлох баримтыг эшлэхгүй ба харин дурдах шаардлагатай бол шүүхийн шийдвэрийн үндэслэх (эрүүгийн хэргийн хувьд тодорхойлох) хэсэгт тухайн баримтыг үнэлж буй хэсгийн (өгүүлбэрийн) ард хаалтан дотор хавтаст хэргийн болон хуудасны буюу талын дугаарыг бичнэ. Жишээ нь: ...шинжээчийн дүгнэлтэд (1 дэх хавтаст хэргийн 50 дахь тал) гэж бичнэ.

3.11.Иргэн болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийн тодорхойлох, үндэслэх болон хянавал хэсэг, эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсгийг дугаарлах ба ингэхдээ нэг утга санаа буюу шүүхээс хийж буй дүгнэлт бүрийг (эсхүл шинэ өгүүлбэр болгоныг) шинэ мөрнөөс үргэлжлүүлэн дугаарлана.

3.12.Шүүгчийн тусгай санал гарсан бол шүүхийн шийдвэрийн үндэслэх болон хянавал хэсгийн төгсгөлд хэдэн шүүгч тусгай санал гаргасныг тусгана. Тусгай санал нь зөвхөн хууль хэрэглээний зөрүүтэй байр суурьтай холбоотой байна. Шүүгч нь нотлох баримтын үнэлгээ, гэм буруугийн асуудлаар тусгай санал гаргахгүй.

3.13.Шүүх бүрэлдэхүүнд оролцсон бүх шүүгч шүүхийн шийдвэрт гарын үсэг зурна. Шийдвэрийг боловсруулсан шүүгч архивд үлдэх эх хувийн хуудас болгоны ар талд (боловсруулсан...хэсэгт) гарын үсэг зурна.

#### Дөрөв.Бусад зүйл

4.1.Анхан шатны шүүхийн шийдвэр, шийтгэвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал (шийдвэр) болон хяналтын шатны шүүхийн тогтоол бичих арга зүйг тус тусын аргачлалаар нарийвчлан зохицуулна.

4.2.Давж заалдах болон хяналтын шатны шүүх хуулиар тусгайлан харьяалуулсан хэрэг, маргааныг анхан, давж заалдах журмаар хянан шийдвэрлэх бол тухайн шатны шүүхийн шийдвэр боловсруулах аргачлалыг баримтална.

4.3. Шүүхийн шийдвэрийн агуулга, хэлбэр, бүтцийн талаар хууль болон энэхүү журам, холбогдох аргачлалд заасан шаардлагыг бүх шатны шүүхийн шүүгч хэлбэрэлтгүй баримталж, шүүхээс гарч буй аливаа эрхийн актын боловсруулалт, найруулгад онцгой анхаарч ажиллах үүрэгтэй.

-----oO-----

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны  
2021 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн  
29 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙТГЭХ (ЦАГААТГАХ)  
ТОГТООЛ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх болон цагаатгах тогтоолыг боловсруулахдаа дараах аргачлалыг баримтлахыг зөвлөж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу шүүхийн шийдвэр нь “удиртгал, тодорхойлох, тогтоох” хэсгүүдээс бүрдэнэ.

Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн Арван долоо дугаар бүлэгт заасны дагуу хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж байгаа бол энэхүү аргачлалд тусгагдсанаас өөр байдлаар буюу шүүхийн шийдвэрийг нь илүү товч хэлбэрээр боловсруулж болно.

Нэг. Тогтоолын удиртгал хэсэг

1.1. Удиртгал хэсэгт шүүхийн шийдвэрийг хэзээ, хаана, ямар шүүх гаргаж байгаа, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогчийг нэрлэн заана.

“Хэзээ” гэдэгт шүүх хуралдаан хэдий хугацаанд үргэлжилсэн гэдгээс үл хамаараад Монгол Улсын нэрийн өмнөөс шүүхийн шийдвэрийг уншиж сонгосон буюу шүүхийн шийдвэр гаргасан өдрийг ойлгож шийдвэрийг огноолно. Огноог “2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр” гэж бүтэн бичнэ.

“Хаана” гэдэгт шүүх хуралдааныг явуулж шүүх шийдвэрээ гаргасан газар, шүүх хуралдааны танхимыг хэлнэ. Зарим тохиолдолд шүүх хуралдааныг тодорхой шалтгаанаар өөр байранд хийсэн бол тухайн байршил, хаягийг тусгана. Шүүх хуралдаан нээлттэй, хаалттай аль хэлбэрээр явагдсаныг тусгана. Шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаалттай явуулж байгаа тохиолдолд энэ нь хуульд заасан үндсэн шаардлага, үндэслэл журамд бүрэн нийцэж байгаа эсэх, түүнчлэн оролцогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцэж байгаа эсэх талаарх үндэслэлийг тодорхой зааж бичнэ.

“Ямар шүүх” гэдэгт хэргийг хянан шийдвэрлэж буй шүүхийг Монгол Улсын шүүх байгуулах тухай хуулиар байгуулагдсан нэрээр тусгана. Тухайлбал “Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх” гэж.

“Шүүх бүрэлдэхүүн болон шүүгч” гэдэгт тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх бүрэлдэхүүн, эсхүл дангаар шийдвэрлэж буй шүүгчийн нэр байна. Шүүгчийн нэрийг эцгийн (эхийн) нэрийн эхний үсгийн хамт бичнэ. Түүнчлэн, шүүгдэгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч нарын нэрийг энэ хэсэгт заана. Харин бусад оролцогч болох иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хохирогч, гэрч, шинжээч нарын нэрсийг зөвхөн шүүх хуралдааны тэмдэглэлд тусгана.

1.2. Энэ хэсэгт тухайн эрүүгийн хэргийн дугаарыг оруулна.

1.3. Шүүгдэгчийн хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.6 дугаар зүйлийн 1.5 дахь хэсэгт заасан биеийн байцаалтын талаарх мэдээллийг оруулахаас гадна төрийн албан ёсны бүртгэлийн эх сурвалж болох тухайн хүний ургийн овог, регистрийн дугаарыг багтаах нь ижил нэртэй өөр хүнийг гэмт хэрэгт хилсээр шийтгэх, эсхүл овог, нэр солигдсон мэдээллээс үүдэн гарч болзошгүй алдаанаас сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнд гагцхүү өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн шаардлагыг хангахад ач холбогдолтой.

Гадаадын иргэн, харьяалалгүй хүний нэрийг гадаад улсын иргэн болохыг гэрчлэх паспорт, паспортыг орлох баримт бичиг дээр, Монгол Улсад оршин суух түр үнэмлэх дээр бичигдсэн англи үсгээр нь бичнэ.

1.4.Тогтоолын удиртгал хэсэгт шүүгдэгчийн холбогдсон эрүүгийн хэргийн товч агуулга, гэмт хэргийн шинжид хамаарч байгаа үйлдэл, үйл баримтыг ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэн бичиж, тухайн хэрэг нь Эрүүгийн хуулийн ямар зүйл, ангид хамаарч байгааг дурдана. Ийнхүү хэргийн товч агуулгыг тодорхойлохдоо яллах дүгнэлтийг хуулбарлахгүйгээр гэмт хэрэг гарсан байдлыг хураангуй боловч бүрэн илэрхийлж бичвэл зохино.

Түүнчлэн, нэг шүүгдэгч хэд хэдэн гэмт хэрэгт холбогдсон, эсхүл хэд хэдэн шүүгдэгч нар хамтарч үйлдсэн тохиолдолд хэргийн агуулгыг бичихдээ, нэг хэрэгт хамаарах үйл баримтын агуулгыг дахин давтаж, нуршуу илэрхийлэлгүй, хамтран оролцооны хэлбэрээр ялгаж, нэгтгэн томъёолж бичих нь гэмт хэргийн талаар эмх цэгцтэй, ойлгомжтой дүр зургийг бий болгох учиртай.

#### Хоёр.Тогтоолын тодорхойлох хэсэг

Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэг нь шүүгдэгчийг гэм буруутайд тооцох болон түүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын талаар дүгнэлт хийсэн бие даасан хэсгүүдээс бүрдэнэ. Харин цагаатгах тогтоолын тодорхойлох хэсэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зүйлс бүрийг тусгана.

#### 2.1.Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэг

Тодорхойлох хэсэг нь гэмт хэргийн үйл баримтын талаарх дүгнэлт болон шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон эрх зүйн дүгнэлтээс бүрдэх учиртай. Энэ хэсэгт хэрэгт авагдсан болон хэргийн оролцогч нарын зүгээс гаргасан, тухайн хэргийн талаар тогтоовол зохих нөхцөл байдалд хамааралтай бүх мэдээлэл агуулагдсан байх ёстой. Иймээс шүүх хуралдаанд шинжлэн судалсан нотлох баримт, баримт сэлт, эд мөрийн баримт нэг бүрийн талаарх мэдээллийг оруулахдаа агуулгын хувьд алдаагүй, товч, ойлгомжтой, логик зохилдлогоог хангасан байдлаар тусгасан байвал зохино.

Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэг нь шүүгдэгчийг гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

2.1.1.Үйл баримт: Шүүхээс нотлогдсон гэж үзсэн гэмт үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гарсан газар, цаг, хугацаа, гэмт хэрэг үйлдсэн арга, гэм буруугийн хэлбэр, сэдэлт, зорилго, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл болон учирсан хохирлын хэр хэмжээ, хор уршгийн шинж бүрээр эргэлзээгүй тодорхойлж бичнэ.

Шүүх хэргийг хянан хэлэлцээд тогтоосон үйл баримтыг дүгнэж бичихдээ прокурорын яллах дүгнэлтэд дурдагдсаныг эсхүл нотлох баримтын агуулгыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хуулбарлах, нотлох баримтын жагсаалтыг бичих байдлаар бус, харин тэдгээрт түшиглэн харьцуулах, нягтлах, батлах, үгүйсгэх зэрэг танин мэдэхүйн аргуудыг хэрэглэн сэргээн тогтоосон үйл явдлыг шүүгч өөрийн үг, өгүүлэмжээр, ойлгомжтой байдлаар дүрслэн илэрхийлж бичих ёстой.

2.1.2. Хэргийн үйл баримтыг тогтоон дүгнэхдээ яллах болон цагаатгах нотлох баримтуудыг хэрхэн үнэлж, дүгнэсэн байдлаа буюу дээр дурдсан байдлаар явагдсан танин мэдэхүйн процессыг завсрын дүгнэлтүүдийн хамт бичиж шүүгч хэрхэн эцсийн дүгнэлтэд хүрснээ дэлгэрэнгүй, эргэлзээгүй энгийн ойлгомжтой байдлаар тайлбарлаж бичнэ. Энэ нь өөрийн итгэн үнэмшсэнийг батлан тогтоох дотогшоо чиглэсэн, бусдыг итгүүлэн үнэмшүүлэх гадаад үйлчлэлийн хүрээнд хоёр талт шинж чанартай байна. Бусдаар гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт зэрэг

үйл баримтын агуулга бүхий нотлох баримтаас анализ дүгнэлт хийхгүйгээр шууд үйл баримтыг тодорхойлох нь нотлох баримт болон тогтоогдож буй үйл баримтын үр дүн хоёрын хамааралт холбоог тайлбарлахаас татгалзаж алгасч буйн улмаас шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байдалд ноцтойгоор нөлөөлнө.

Шүүгч өөрийн зүгээс нотлох баримтуудыг шалгаж үнэлсэн байдлыг тухайлбал, нотлох баримтыг үнэлсэн, үнэлээгүй үндэслэлийг, шаардлага хангасан, хангахгүй байгаа, эсхүл нотлох чадвартай, чадваргүй, хэрэгт хамааралтай, хамааралгүй болон үйл баримтыг тогтооход ач холбогдолтой, холбогдолгүй байгааг, мөн нөгөө талууд тухайн баримтыг хэрхэн үгүйсгэж байгаа, түүнийг шүүх зөвшөөрч буй, эсхүл няцааж буй дүгнэлтээ бичнэ.

Нотлох баримт нь нэгдүгээрт, хянан шийдвэрлэж байгаа хэрэг маргааны талаар нотолбол зохих зүйлд хамааралтай, ач холбогдол бүхий байх, хоёрдугаарт, хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу цуглуулсан буюу хүлээн зөвшөөрөгдөхүйц байх, гуравдугаарт, үнэн бодит байдлыг илэрхийлсэн байх, эцэст нь буюу дөрөвдүгээрт, тухайн асуудлыг шийдвэрлэхэд хангалттай байх шинж чанаруудын аль алиныг нь хангасан эсэхийг нягтлан үзэх ёстой.

Шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг хэрэглэхдээ эргэлзээ бүхий үйл баримтыг нотлогдоогүйд тооцохоос бус өөр аль нэгэн нотлогдоогүй үйл баримтыг тогтоогдсонд тооцох үндэслэл болгож болохгүй. Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгч, эсхүл шүүгдэгч нарт холбогдох хэргийг нэг шийтгэх тогтоолоор шийдвэрлэж байгаа бол нэг үйл баримтын агуулгыг нуршиж давталгүй, тус бүрийн үйлдлийг хамтран оролцооны хэлбэрээр ялгаж, нэгдмэл байдлаар томьёолж бичих, үйлдлийн шинжээс хамаарч эрх зүйн өөр үр дагаварт хүргэж буй үндэслэл зэргийг дүгнэж бичнэ.

2.1.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдсан эсэх, хэргийн оролцогчийн хууль ёсны эрхийг зөрчсөн эсэх, хэрэв зөрчсөн бол энэ нь ноцтой зөрчилд хамаарах эсэх талаар дүгнэлтийг энэ хэсэгт оруулна.

2.1.4. Эрх зүйн үндэслэлийг тодорхойлох: Шүүх тогтоосон үйл баримтыг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой гэмт хэргийн шинж, хэргийн оролцогч нарын хэрэглэх ёстой гэж үзэж буй эрх зүйн үндэслэл зэргийг харьцуулан хянаж, шүүгдэгчийн хувьд хэрэглэгдэх ёстой гэж үзэж байгаа эрүүгийн эрх зүйн хэмжээг тодорхойлно.

Эрх зүйн дүгнэлт. Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож дүгнэсэн хэсэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-2.5 дэх хэсгүүдэд заасан зүйлсийг нэг бүрчлэн дүгнэж бичих бөгөөд шүүгдэгчийн үйлдэл, эс үйлдэхүй нь тодорхой гэмт хэргийн зүйлчлэл, түүний объектив болон субъектив шинжид хамаарах элемент (бүрдүүлбэр) нэг бүрт бүрэн нийцэж байгааг тодорхойлсон үндэслэл, өөр өрсөлдөх хэм хэмжээний талаарх дүгнэлт, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, үйлдлийн арга, гэм буруугийн хэлбэр, хэр хэмжээ, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж, хэр хэмжээ, үйлдэл, үр дагавар хоорондын шалтгаант холбоо зэргийн талаарх дүгнэлтийг багтаана.

Шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг хуулийг тайлбарлах, хэрэглэх явцад хэрэглэхдээ юуны өмнө хуулийн заалтын утга агуулгын талаар эрх зүйн хийдэл буюу зохицуулалтгүй, эсхүл салаа утгаар ойлгож болохоор нөхцөл байдал үүссэнийг тогтоож шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх хувилбараар тайлбарлана. Шүүгдэгчид ашиггүй гэсэн үндэслэлээр тодорхой хэм хэмжээг хэрэглэхээс шүүх татгалзаж болохгүй.

2.1.5. Эрүүгийн хариуцлага оногдуулах: Шүүхээс аливаа гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага оногдуулахдаа тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал,

учирсан хохирол, хор уршиг, шүүгдэгчийн хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзэх үүрэгтэй бөгөөд ингэхдээ эрүүгийн хариуцлагын нийтлэг зорилгыг хангах, түүнчлэн гэмт үйлдлийн шинж чанар болон ял шийтгэлийн хэр хэмжээ нь хоорондоо хамгийн зүй зохистой харьцаагаар нийцсэн байх шударга ёсны зарчимд хэрхэн нийцсэн байгааг дүгнэж бичнэ.

Шүүгдэгчид эрүүгийн хариуцлага оногдуулсан хэсгийг дурдахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1-3.6 дахь заалтад заасан асуудал бүрийг тухайн дэс дарааллыг баримтлан нэг бүрчлэн дүгнэж бичих ёстой.

Шүүх эрүүгийн хариуцлага оногдуулахдаа Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал нэг бүрийг хянаж дүгнэх, мөн тухайн зүйлд заагаагүй боловч шүүхээс үнэлж тодорхойлсон зарим онцгой нөхцөл байдлыг хөнгөрүүлэх үндэслэлд хамааруулан дүгнэлт хийж болох бөгөөд тэдгээр нь уг гэмт хэрэгт оногдуулахаар хуульчлан тогтоосон ял шийтгэлийн төрөл, хэр хэмжээг тодорхойлоход ямар харьцаагаар нөлөөлсөн талаарх дүгнэлт хийгдсэн байвал зохино.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 6.6 дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал байгаа эсэхийг дүгнэж, тэдгээр нь ял шийтгэлийн төрөл, хэр хэмжээг тодорхойлоход ямар харьцаагаар нөлөөлснийг дүгнэж бичих ба харин ингэхдээ тухайн зүйлд заагаагүй, эсхүл тодорхой гэмт хэргийн шинж болгон тодорхойлсон нөхцөл байдлыг эрүүгийн хариуцлага хүндрүүлэх үндэслэлд тооцохыг хориглодог болохыг анхаарах хэрэгтэй.

Шүүгдэгчийг ялаас чөлөөлөх, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх, хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа шүүх Эрүүгийн хуулийн 6.7, 7.1, 7.6, 8.6 дугаар зүйлүүдэд нэрлэн заасан чухам ямар нөхцөл байдлыг үндэслэн тухайн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх боломжтой гэж дүгнэх болсон шалтгааныг заана.

Эрүүгийн хуулийн тухайн зүйл, хэсэг нь сонгох ялтай тохиолдолд шүүх гэм буруутай этгээдэд тухайн ялыг оногдуулах болсон үндэслэлээ тодорхой дурдана.

Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон болон согтуурах, мансуурах донтох эмгэгтэй болох нь тогтоогдсон этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн бол үндэслэлийг дурдана.

2.1.5.Бусад асуудал: Иргэний нэхэмжлэл буюу гэмт хэргийн улмаас учирсан хохирлын талаар шүүхээс гаргасан шийдвэрийн үндэслэлийг энэ хэсэгт дурдаж өгнө.

Шүүх нэхэмжлэлийг бүгдийг буюу хэсэгчлэн хангаж байгаа, эсхүл хэрэгсэхгүй болгосон үндэслэл, нэхэмжлэлийн шаардлагыг хангасан хэмжээ, иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэхэд баримталсан хууль зэргийг заана.

Иргэний нэхэмжлэлийг ханган шийдвэрлэхдээ шүүх гаргавал зохих мөнгөний хэмжээ, түүнийг гаргуулах болон олгох этгээдийг дурдана.

Гэмт хэргийг хэд хэдэн шүүгдэгч үйлдсэн бол тэдгээр нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хамтран эсхүл өөрт ногдох хувийн алинаар хариуцахыг тодорхой заана.

Хэрэв иргэний нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд гаргасан бол хангасан шаардлага бүрийн хэмжээг шүүх тодорхой заах үүрэгтэй.

Хэрэг хэлэлцэх ажиллагааг хойшлуулахгүйгээр иргэний нэхэмжлэлийн тодорхой тооцоог гаргах бололцоогүй тохиолдолд шүүх иргэний нэхэмжлэгч нь нэхэмжлэлээ иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар хангуулах эрхтэй

болохыг зааж, түүний хэмжээний тухай асуудлыг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар шийдвэрлүүлэхээр шилжүүлж болно.

Шүүгдэгчид Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасан хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан тухай нэг бүрчлэн заана.

Шүүгдэгч тогтоол гарахын өмнө цагдан хоригдож байсан бол түүний урьд цагдан хоригдсон хоногийг эдлэх ялд нь оруулах талаар бичнэ.

Хэрэгт хураагдан ирсэн эд мөрийн баримтыг хэрхэн шийдвэрлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал гаргуулах, хуваарилах талаар заана.

## 2.2.Цагаатгах тогтоолын тодорхойлох хэсэг

Энэ хэсэгт тухайн үйлдлийг шүүгдэгч хийгээгүй буюу хийсэн үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдохгүй гэдгийг үндэслэх шаардлагатай.

2.2.1.Яллагдагчийг шүүхэд шилжүүлсэн хэргийн агуулгыг дурдахдаа шүүгдэгчийг буруутгаж буй үйлдэл, эс үйлдэхүй нь юу болох, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн гэх цаг, газар, гэмт хэргийн улмаас учирсан хохирол зэргийг товч, ойлгомжтой бичнэ. Ингэхдээ яллах дүгнэлтийн үндэслэл болсон нотлох баримтыг мөн дурдана. Тухайлбал: гэрч, хохирогчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлтээс иш татах, эд мөрийн баримтын тухай тодорхой оруулж заана.

2.2.2.Шүүхээс хэргийн талаар тогтоосон байдлыг тусгана. Энэ хэсэгт яллах үндэслэл болж байсан баримтыг шүүх ямар учраас үгүйсгэсэн, шүүгдэгчийг цагаатгах үндэслэл болон үүнийг баталж байгаа нотлох баримтыг дурдана. Үүнд:

а.ял сонсгох үндэслэл болсон нотлох баримтыг өөрөөр тайлбарлах;

б.улсын яллагч анхаарч үзэлгүй орхигдуулсан шинэ нотлох баримтыг гаргах;

в.тухайн гэмт хэрэг үйлдэхэд шүүгдэгч оролцоогүй болохыг нотолсон шинэ нөхцөл байдлыг шүүх тогтоох зэрэг хамаарна. Жишээ нь, шүүгдэгч гэмт хэрэг гарах үед өөр газар байсан нь түүний гэм буруугүйн нотолгоо болсон гэх мэт.

2.2.3.Тухайн эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг хянан хэлэлцсэн боловч шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд болон яллах талын цуглуулсан нотлох баримтын талаар эргэлзээ төрвөл “эргэлзээтэй бол шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ” гэсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлд заасан зарчмыг шүүх удирдлага болгож шийдвэрлэнэ. Ингэхдээ шүүх өөрийн эргэлзэх болсон үндэслэлээ тодорхой тайлбарлана. Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ төрвөл дээрх журмыг баримтална.

## Гурав.Тогтоолын тогтоох хэсэг

### 3.1.Шийтгэх тогтоолын тогтоох хэсэг

Шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтад заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон тухай дүгнэлт, түүнд оногдуулсан ял болон хэргийн талаар шүүхээс гаргасан бусад шийдвэрүүдийг заана. Ийнхүү заахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан дарааллыг баримтална.

Тогтоолын бүх хэсэг нь хоорондоо харилцан уялдаа холбоотой тул тогтоох хэсэг нь удиртгал болон тодорхойлох хэсгийн үргэлжлэл юм. Тогтоох хэсэг нь удиртгал болон тодорхойлох хэсэгтэй зөрчилдвөл тогтоолыг үндэслэлгүй болсон гэж үзнэ.

Тогтоох хэсгийг шүүхээс оногдуулсан ялын төрөл, хэмжээний талаар ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар томъёолсон байвал зохино.

3.1.1.Шүүгдэгчид оногдуулсан үндсэн болон нэмэгдэл ялын төрөл, хэмжээ, хэд хэдэн гэмт хэрэгт болон хэд хэдэн тогтоолоор ял шийтгүүлсэн этгээдийн жинхэнэ эдэлбэл зохих үндсэн болон нэмэгдэл ял зэргийг тодорхой заана.

3.1.2.Шүүгдэгчид Эрүүгийн хуулийн хэд хэдэн зүйл, хэсэгт заасан гэм хэрэгт яллах дүгнэлт үйлдсэн бөгөөд шүүх тэдгээрийн заримыг хэрэгсэхгүй болгосон бол аль хэрэгт нь шийтгэж, аль хэрэгт нь цагаатгасныг тогтоох хэсэгт нэг бүрчлэн тусгана.

3.1.3.Хэд хэдэн гэмт хэрэгт болон хэд хэдэн тогтоолоор хорих ял шийтгүүлсэн шүүгдэгчийн жинхэнэ эдэлбэл зохих ялын хэмжээг Эрүүгийн хуулийн 6.8, 6.9 дүгээр зүйлд заасан журмаар шийдвэрлэсний дараа түүний ял эдлэх дэглэмийг шүүх тогтооно.

3.1.4.Шүүгдэгчийг ялаас чөлөөлөх үндэслэлтэй гэсэн дүгнэлтэд шүүх хүрвэл тогтоох хэсэгт түүнийг гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн зохих зүйл, хэсэгт заасан ял оногдуулсны дараа ялаас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ.

3.1.5.Хорих ялыг оногдуулахгүйгээр тэнсэх тохиолдолд шүүх тогтоох хэсэгт Эрүүгийн хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ямар хугацаагаар тэнсэж буйг болон 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан ямар үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож байгааг тодорхой заана.

Мөн хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулах тохиолдолд дээрх журмыг баримтална.

3.1.6.Согтуурах, мансуурах донтох эмгэгтэй болох нь тогтоогдсон хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх болсон үндэслэлээ шүүх тодорхойлох хэсэгт дурдаж, энэ тухай шийдвэрийг тогтоох хэсэгт заана.

3.1.7.Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ шүүх тогтоох хэсэгт шүүгдэгчийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг, эсхүл тодорхой эд зүйлийг хурааж буйгаа болон хураах эд зүйл, эд хөрөнгийг нэг бүрчлэн заана.

3.1.8.Хорих ял шийтгүүлсэн хоригдлын шууд асрамжид байсан бага насны буюу насанд хүрээгүй хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжүүлэхээр төрөл садан буюу бусад хүмүүст, эсхүл зохих байгууллагад шилжүүлэн өгөх, эзэнгүй үлдсэн тэдгээрийн эд хөрөнгө, орон сууцыг хамгаалах арга хэмжээ авсан бол энэ тухай тогтоох хэсэгт дурдана.

3.1.9.Шүүх нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авсан эсэх, түүнийг хэн, ямар журмаар биелүүлэхийг заана.

Иргэний нэхэмжлэл буюу гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэх тухай асуудлыг шийдвэрлэхдээ тогтоох хэсгийг ойлгомжтой, эргэлзээ төрүүлэхгүй байхаар томьёолон бичнэ.

3.1.10.Шүүгдэгч тогтоол гарахын өмнө цагдан хоригдож байсан бол түүний урьд цагдан хоригдсон хоногийг эдлэх ялд нь оруулж тооцохоор шүүх шийдвэрлэнэ.

3.1.11.Хэрэгт хураагдан ирсэн эд мөрийн баримтыг хэрхэн шийдвэрлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал гаргуулах, хуваарилах талаар заана.

3.1.12.Тогтоох хэсэгт шийтгэх тогтоол уншиж сонсгосноор хүчинтэй болохыг дурдаж, тогтоолд давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд гардан авсан буюу хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол, эсэргүүцлийг давж заалдах шатны шүүхэд гаргахыг заана.

### 3.2.Цагаатгах тогтоолын тогтоох хэсэг

Цагаатгах тогтоолын тогтоох хэсгийн үндсэн асуудал нь шүүгдэгчийг гэм буруугүйд тооцож, цагаатгах явдал юм.

Цагаатгах тогтоолын тогтоох хэсгийг үйлдэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан дарааллыг баримтална.

3.2.1.Шүүх шүүгдэгчийн ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, түүнчлэн яллах дүгнэлт үйлдсэн Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, цагаатгах шийдвэрийг заана. Ингэхдээ шүүх гэмт хэрэг гарсан нь тогтоогдоогүй, шүүгдэгчийн үйлдэл нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон болох нь нотлогдоогүй зэрэг хуульд заасан аль үндэслэлээр шүүгдэгчийг цагаатгасан болохыг тодорхой заана.

3.2.2.Түүнчлэн шүүх энэ хэсэгт таслан сэргийлэх арга хэмжээ болон иргэний нэхэмжлэл ба эд хөрөнгө хурааж болзошгүй байдлыг хангах талаар авсан арга хэмжээг хүчингүй болгоно.

3.2.3.Гэмт хэрэг гарсан нь тогтоогдоогүй буюу шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь нотлогдоогүй тохиолдолд шүүх иргэний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно. Харин шүүгдэгчийн үйлдэл гэмт хэргийн шинжгүйгээс түүнийг цагаатгасан бол нэхэмжлэлийг хэлэлцэхгүй орхино.


3.2.4.Цагаатгах тогтоолд шүүгдэгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хохирлоо арилгуулахаар гомдол гаргах эрхтэй болохыг тусгана.

3.2.5.Хэрэгт хураагдан ирсэн эд мөрийн баримтыг хэрхэн шийдвэрлэхийг заана.

3.2.6.Цагаатгах тогтоолд давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхтэй болохыг тусгана.

-----o0o-----

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны  
2021 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн  
29 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт



## ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН МАГАДЛАЛ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал боловсруулахад дараах аргачлалыг баримтлахыг зөвлөж байна.

1. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал нь анхан шатны шүүхийн шийдвэрт хуулиар тавигддаг тэр л шаардлагын дагуу үйлдэгдсэн, хууль ёсны ба үндэслэлтэй байхаас гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүтэц, хэлбэртэй байх бөгөөд шийтгэх тогтоолыг хянасан магадлалын хувьд мөн хуулийн 36.6, 36.7, 36.8 дугаар зүйлд, цагаатгах тогтоолыг хянасан магадлалын хувьд 36.6, 36.9 дүгээр зүйлд тус тус заасан хэсгээс бүрдэнэ.

2. Давж заалдах шатны шүүхийн магадлал нь төрийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартад нийцсэн, утга санааг бүрэн зөв илэрхийлсэн, албан ёсны болон хууль зүйн үг хэллэг ашигласан, товч тодорхой, ойлгомжтой, логик дэс дараалалтай, агуулга, найруулгын хувьд зөрчилгүй бичигдсэн байвал зохино.

3. Давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцлээс прокурор, дээд шатны прокурор, оролцогч нь шүүгч хэргийн талаар илтгэхээс өмнө татгалзаж болох бөгөөд энэ тохиолдолд шүүхээс тогтоол гаргана.

5. Тодорхой баримт бичиг, баримтат мэдээллүүдийг хянан дүгнэж, үйл баримтыг сэргээн тогтоож, түүнд эрх зүйн дүгнэлт хийж буй эрх бүхий хүмүүсийн шийдвэр, тэдгээрийн үндэслэлийг шатлан хянаж, үүнтэй холбоотойгоор өөр өөр баримт бичигт үндэслэн, тэдгээрийг ахин дахин дурдахад хүрдэг онцлогоос хамаарч шүүхийн шийдвэрийн бичвэрт догол мөр, үечлэл ашиглах, түүнчлэн тоо буюу үсгээр дугаарлах нь тухайн баримт бичиг тодорхой, ойлгоход хялбар байх үүднээс чухал ач холбогдолтой тул тогтоолын санааг бүлэглэн хувааж дугаарлах хэрэгтэй. Шийдвэрийг догол мөрөөр дугаарласнаар шүүхийн дүгнэлт агуулсан хэсэг бүрийн талаар талууд санал илэрхийлэх, дүгнэлт өгөх, түүнийг хянан үзэж буй этгээд төвөггүй олоход хялбар болгож, шийдвэрийн маргаан дагуулж буй хэсгийн талаар андуурал гарахаас сэргийлэхээс гадна сургалт, судалгааны эргэлтэд оруулах үед шийдвэрийн хэсэг бүрт хүрч ажиллах боломжийг бүрдүүлэх юм. Өөрөөр хэлбэл, шүүхийн хэргийн талаарх завсрын болон эцсийн дүгнэлтүүдийг бүгдийг талбарын нэгжээр хаягжуулснаар түүнийг хянах тогтолцоог боловсронгуй болгосон гэж ойлгож болно. Шүүгчид шийдвэрийнхээ утга санаа, үндэслэлийг ямагт ил гаргаж тавин шүүмжлэл, няцаалтаар сорьж байхаас бус түүнийг бүтцийн талаас далдалж нуух учир шалтгаан байх ёсгүй.

6. Тогтоолд эрх зүйн онолын ойлголт болон бусад хууль зүйн баримт бичгийн бичвэр, томъёоллыг бүхэлд нь, эсхүл давхардуулан тусгахгүй үүднээс эш татах нь зохимжтой гэж үзсэн бол эшлэлийг тодорхой хийж, тэдгээр баримт бичгийн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх хэрэгтэй. Харин шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон, шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримт нь тогтоолын үндсэн бүрдэл хэсэгт тусгагдсан байх ёстой учир түүнийг эш татаж болохгүй.

7. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт тусгагдах дүгнэлтүүд нь тухайн шатны шүүхийн шийдвэр гаргах хүрээ хязгаарт багтааж анхан шатны шүүхийн

шийтгэх, цагаатгах тогтоолд эрх зүйн болон үйл баримтын талаас аль алианаас дүгнэлт хийх эрхтэй боловч үйл баримтыг зөвхөн магадлах ба шинээр тогтоохгүй.

#### Нэг.Магадлалын удиртгал хэсэг

1.1.Магадлалд хэзээ, хаана ямар шүүх гаргаж байгаа, шүүх бүрэлдэхүүн, давж заалдах шатны шүүх хуралдааны оролцогчийг нэрлэн заахын зэрэгцээ хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн нэр, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шийдвэрийн огноо, дугаарыг зааж, тухайн шийдвэрийг хэний (хэргийн аль оролцогчийн) давж заалдах журмаар гаргасан гомдлын дагуу хэн шүүгчийн илтгэснээр хэлэлцэж байгааг заана.

1.2.Яллагдагч, шүүгдэгчийн биеийн байцаалтын талаарх мэдээллийг болон ял шийтгүүлж байсан бол аль шүүхийн, хэдэн оны, хэдэн сарын, хэдний өдрийн хэдэн тоот шийтгэх тогтоолоор ямар ялаар шийтгүүлж байсныг тусгана.

1.3.Үйл баримт: Холбогдсон хэргийн үйл баримтыг яллах дүгнэлт, анхан шатны шүүхээс тогтоосон хэргийн үйл баримтын хүрээнд тусгах бөгөөд нэг шүүгдэгч хэд хэдэн гэмт хэрэгт холбогдсон бол хэргийн үйл баримт тус бүрээр, харин хэд хэдэн шүүгдэгч хамтарч үйлдсэн гэмт хэргийн хувьд хэргийн үйл баримтыг хамтран оролцооны хэлбэрээр тус тус ялгаж, нэг удаа бичих нь тухайн тогтоол эмх цэгцтэй, ойлгомжтой байх процессын хуулиар тогтоосон шаардлагад нийцнэ.

1.4.Процессын түүх: Анхан шатны шүүх хэргийг хэрхэн шийдвэрлэснийг буюу шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн шаардлагатай гэж үзсэн мэдээллийг тусгах бөгөөд хэргийг прокурорт буцаасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолтой хэргийн хувьд буцаах үндэслэлийн гол агуулгыг, түүнчлэн захирамжлах, тогтоох хэсгийн ач холбогдол бүхий хэсгийг тус тус бичнэ.

1.5.Давж заалдах гомдлын агуулга: Хэргийн оролцогчоос гаргасан давж заалдах гомдлын үндэслэл бүрийг агуулгаар нь дугаарлан, тусгана.

1.6.Бусад оролцогчийн байр суурь: Хэргийн бусад оролцогч давж заалдах гомдолд тайлбар бичсэнийг болон шүүх хуралдаанд биечлэн оролцсон оролцогчоос тайлбар, дүгнэлт гаргасныг дарааллаар нь оруулна.

#### Хоёр.Магадлалын тодорхойлох хэсэг

2.1. Магадлалын тодорхойлох хэсэг нь анхан шатны шүүхийн шийдвэр нь хуулийн ёсны бөгөөд үндэслэл бүхий гарсан эсэхийг хянан дүгнэсэн, давж заалдах шатны шүүхийн магадлалын хууль зүйн үндэслэгээ бүхий чухал хэсэг байдаг.

2.1. Давж заалдах шатны шүүхээс эрүүгийн хэргийг хэрхэн шийдвэрлэснийг энэ хэсэгт тусгана. Жишээ нь: “Шүүгдэгчийн өмгөөлөгчийн дааж заалдах журмаар гаргасан гомдол үндэслэлтэй. Анхан заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг хэрэглэсэн байна.” гэх мэт.

Эрх зүйн үндэслэл: Хэргийн оролцогчоос давж заалдах журмаар гаргасан гомдлыг хангасан/хангаагүй эрх зүйн үндэслэлийг буюу гомдол гаргагчийн маргаж буй хууль зүйн үндэслэлд дүгнэлт өгнө. Давж заалдах журмаар гаргасан гомдлын үндэслэлээс хамаарч эрх зүйн үндэслэл хэсэг нь дараах дэд хэсгүүдтэй (бүгд эсхүл зарим нь) байж болно:

2.1.1.Тухайн хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой онолын болон харьцуулсан судалгааны хэсэг;

2.1.2.Тухайн асуудалтай холбоотой Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар байгаа эсэх, байгаа бол хэрхэн тайлбарласныг (эшлэл хийн) тусгах;

2.1.3.Ижил төстэй хэргийг өмнө шийдвэрлэсэн байдал (эшлэл заан, дүгнэх байдлаар);

2.1.4.Анхан шатны шүүх холбогдох хуулийг буруу хэрэглэсэн байдлаар тайлбарласан;

2.1.5.Тухайн хэрэг маргааныг ямар онолын үндэслэл, харьцуулсан судалгаа, Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг харгалзан үзэж, холбогдох хуулийг хэрхэн тайлбарлан хэрэглэж (хууль тайлбарлах аргаар), ямар эрх зүйн эцсийн үр дагаварт хүрснээ тодорхойлж, түүнийг анхан шатны шүүх хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн, аль нь зөв болохыг, эсхүл анхан шатны шүүх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарласан нь зөв/буруу болохыг дүгнэж, шийдвэрийг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэнэ.

Харин хэргийн оролцогчоос “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн” үндэслэлээр давж заалдах журмаар гаргасан гомдлыг хянан хэлэлцсэн бол тогтоолын Тодорхойлох хэсэгт тухайн процессын зөрчил нь ямар учраас шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэж үзэж байгааг тайлбарлаж, шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, анхан шатны шүүхэд буцаах үндэслэлтэй болохыг дүгнэнэ.

#### Гурав.Магадлалын тогтоох хэсэг

Энэ хэсгийн эхэнд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх, өөрчлөлт оруулах, хүчингүй болгоход баримтлах холбогдох хуулийн зүйл, заалт, хэсгийг удирдлага болгоно.

3.1.Магадлалын тогтоох хэсэг нь удиртгал болон тодорхойлох хэсгийн үргэлжлэл тул харилцан уялдаа холбоотой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхээргүй, утга агуулгын хувьд зөрчилгүй байх бөгөөд магадлалын тогтоох хэсэгт давж заалдах шатны шүүхээс гарсан шийдлийг тодорхой тусгана.

а.Анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий гэж үзвэл хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгоно.

б.Давж заалдах шатны шүүх нь хэргийн зүйлчлэлийг өөрчлөн ялыг хөнгөрүүлсэн, эсхүл шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлсэн бол анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт ямар нэмэлт заалт, эсхүл тогтоох хэсгийн аль заалтад ямар өөрчлөлт оруулснаа тодорхой заахын зэрэгцээ гомдол, эсэргүүцлийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүлээж авсныг мөн заана.

в.Анхан шатны шүүх хуулийг буруу хэрэглэсэн нь хэргийг дахин хэлэлцүүлэх үндэслэл болсон, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэж үзвэл шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгон анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаахдаа урьдчилсан хэлэлцүүлэгт, эсхүл шүүх хуралдаанаар дахин хэлэлцүүлэхээр буцааж байгааг заахын зэрэгцээ гомдол, эсэргүүцлийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүлээж авсныг мөн заана. Түүнчлэн хэргийг анхан шатны шүүхээр хэлэлцэх хүртэл яллагдагч, шүүгдэгчид ямар таслан сэргийлэх арга хэмжээ авахыг шийдвэрлэнэ.

г.Мөрдөн шалгах ажиллагааны үед хуулийг буруу хэрэглэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гарсан нь тогтоогдвол хэргийг

прокурорт буцааж, гомдол, эсэргүүцлийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүлээж авсныг заах бөгөөд хэргийг прокурорт очтол яллагдагч, шүүгдэгчид авсан таслах сэргийлэх арга хэмжээний талаар тогтоох хэсэгт заана.

3.2.Хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн тохиолдолд Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг тогтоох хэсэгт заавал баримтлахаас гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зүйлийг магадлалын энэ хэсэгт нэг бүрчлэн тусгана.

3.3.Магадлалын тогтоох хэсэгт хяналтын журмаар гомдол гаргах, эсэргүүцэл бичих үндэслэл болон хугацааг тодорхой заана.

3.4.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.14 дүгээр зүйлд заасан журмын дагуу магадлалд үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй гарсан алдааг засахдаа шүүхийн тогтоол гаргана.

Дээрх тохиолдолд залруулга хийх болсон болон тухайн асуудлыг техникийн шинжтэй алдаа гэж үзсэн үндэслэлээ тодорхой тусгаж, шүүхийн шийдвэрийн аль хэсэгт хэрхэн тусгагдсан ямар зүйл (үг, үсэг, тоо, тооцооны алдаа)-ийг хэрхэн өөрчилж байгааг тодорхой, ойлгомжтой бичнэ.

Давж заалдах шүүхийн шийдвэрт залруулга хийсэн шүүхийн тогтоолын тогтоох хэсэгт давж заалдах шатны шүүхийн нэр, шүүхийн шийдвэрийн огноо, дугаарыг заавал тусгана.

-----oOo-----

## Загвар 1 (Магадлалаар шийтгэх тогтоолыг хэвээр үлдээх)

### МАГАДЛАЛ

...-д холбогдох эрүүгийн  
хэргийн тухай

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч ... даргалж, шүүгч ..., ... нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн шүүх хуралдааны танхимд нээлттэй (хаалттай) хийсэн шүүх хуралдаанд:

прокурор ...,

хохилогч ...,

шүүгдэгч ...,

өмгөөлөгч ...,

нарийн бичгийн дарга ... нарыг оролцуулан,

... дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч ... даргалж, шүүгч ... нарын бүрэлдэхүүнтэй хийсэн шүүх хуралдааны ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаартай шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч шүүгдэгч М-ийн өмгөөлөгч Ч-гийн гаргасан давж заалдах гомдлоор шүүгдэгч М-д холбогдох ... дугаартай эрүүгийн хэргийг... оны ... дугаар сарын ...-ны өдөр хүлээн авч, шүүгч М-ийн илтгэснээр хянан хэлэлцэв.

... овгийн М-ийн О, ... оны ... дугаар сарын ...-ны өдөр ... аймагт төрсөн, ... нас, хүйс, боловсрол, мэргэжил, эрхэлсэн ажил, ам бүл, ... нарын хамт Б дүүргийн ... дүгээр хороо, ... дугаар байрны ... тоотод оршин суух бүртгэлтэй, хэрэгт ач холбогдол бүхий биеийн байцаалтын талаарх бусад мэдээлэл, ял шийтгэлгүй, (РД: ...);

Урд ял шийтгүүлж байсан бол аль шүүхийн, хэдэн оны, хэдэн сарын, хэдний өдрийн хэдэн тоот шийтгэх тогтоолоор ямар ялаар шийтгүүлж байсныг бичнэ.

Холбогдсон хэргийн үйл баримтыг яллах дүгнэлт, анхан шатны шүүхээс тогтоосон хэргийн үйл баримтын хүрээ хязгаараас гаргахгүйгээр энэ хэсэгт тусгана.

С дүүргийн прокурорын газраас: М-ийн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн ... дүгээр зүйлийн ... дэх хэсгийн ... дэх заалтад зааснаар зүйлчлэн яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлжээ.

С дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх: Гэм буруутай байдлыг тогтоосон, Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, хэсгээр ял оногдуулсан, ялыг нэмж нэгтгэсэн, дэглэм тогтоосон, цагдан хоригдсон хоног тооцсон, хохирол гаргуулахаар шийдсэн, гэмт хэрэг үйлдэж олсон орлого, хөрөнгө зэргийг улсын орлого болгосон, хөрөнгө битүүмжилсэн, эд мөрийн баримтыг шийдвэрлэсэн зэрэг заалтуудыг болон бусад шаардлагатай гэж үзсэн заалтуудыг оруулах.

Шүүгдэгч М-ийн өмгөөлөгч Ч давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: "... Давж заалдах гомдлын гол санаануудыг товчлон оруулах. Гэхдээ гомдол гаргасан оролцогчийн гомдлын үндэслэл, бүтэц, агуулгыг алдагдуулж болохгүй. Хэрвээ алдагдахаар байвал товчлох шаардлагагүй.

Шүүх хуралдаанд оролцож байгаа оролцогч нарын тайлбарыг оруулна.

Прокурорын шүүх хуралдаанд гаргасан дүгнэлтийг тусгана.

#### ТОДОРХОЙЛОХ НЬ:

Давж заалдах шатны шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэгт зааснаар давж заалдах гомдолд заасан асуудлаар хязгаарлахгүйгээр хэргийн бүх ажиллагаа, шийдвэрийг бүхэлд нь хянасан байдлыг оруулна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих асуудлуудыг хангалттай шалгаж тодруулсан, хэрэгт авагдсан нотлох баримтын хүрээнд хэргийг эцэслэн шийдвэрлэсэн нь үндэслэлтэй болсныг заана.

Хэргийн үйл баримтыг тогтооход үндэслэл болсон нотлох баримтуудыг цуглуулах, бэхжүүлэх, үнэлэх шатанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шаардлагыг зөрчөөгүй талаар дүгнэнэ.

М нь ... (хэд хэдэн шүүгдэгчийн хамтран оролцоотой үйлдэгдсэн хэргийн үйл баримтыг нэгтгэж бичихдээ шүүгдэгч тус бүрийн үйлдэл, оролцоо, хамтран оролцсон хэлбэрийг тусгана) гэмт хэрэг үйлдсэн болох нь:

хохирогч Ц-гийн "... (хх 24) гэсэн,

гэрч А-гийн "... (1 хх 35-36) гэсэн тус тус мэдүүлгүүд, (мэдүүлгийн гол хэсгийг товч оруулна)

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн "... гэсэн ... дугаартай шинжээчийн дүгнэлт (1 хх 81-82),

хэргийн газрын үзлэг хийсэн тэмдэглэл, гэрэл зургийн үзүүлэлтүүд (1 хх 10), эд мөрийн баримт (1 хх 21) зэрэг хэрэгт цуглуулж, бэхжүүлсэн, анхан шатны шүүхийн шүүх хуралдааны хэлэлцүүлгээр хэлэлцэгдсэн хэрэгт хамааралтай, ач холбогдол бүхий нотлох баримтуудаар нотлогдсон байдлыг заана.

Дээрх байдлаар нотлох баримтыг заахдаа, бүх нотлох баримтыг оруулахгүйгээр хэрэгт хамааралтай, ач холбогдол бүхий нотлох баримтыг бичих бөгөөд ингэхдээ, тухайн нотлох баримтын агуулгыг өөрчлөхгүйгээр гол хэсгийг оруулна.

Харин бусад нотлох баримтын хувьд, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтуудыг няцаан үгүйсгээгүй, харин давхар нотолж байгаа талаар тайлбарлана.

Олон үйлдэлтэй залилан, хулгай, дээрмийн гэмт хэргийн нотлох баримтыг хохирогч А (1 хх 22), Б (2 хх 36), В (3 хх 23), гэрч А (1 хх 22), Б (2 хх 36), В (3 хх 23) нарын мэдүүлэг, хэргийн газрын үзлэг хийсэн тэмдэглэл, гэрэл зургийн үзүүлэлтүүд (1 хх 10, 2 хх 35, 3 хх 50), эд мөрийн баримт (1 хх 21, 2 хх 21, 3 хх 99) зэрэг хэрэгт цуглуулж, бэхжүүлсэн, анхан шатны шүүхийн шүүх хуралдааны хэлэлцүүлгээр хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар нотлогдон тогтоогджээ гэж бичиж болно.

Хэд хэдэн шүүгдэгч гэмт хэрэг хамтран үйлдсэн бол хамтран оролцсон шүүгдэгч тус бүрийн үйлдсэн гэмт хэрэг хэрхэн нотлогдож байгаа талаарх нотлох баримтыг заана.

Нотлох баримт харилцан зөрүүтэй байхад аль нэгийг нь үнэлж шүүхийн шийдвэрийн үндэслэл болгосон, эсхүл ямар нотлох баримтыг үнэлэхгүй орхисон үндэслэлийг заавал заана.

Шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэргийн талаар хийсэн анхан шатны шүүхийн дүгнэлт хэргийн бодит байдалтай нийцсэн талаар дүгнэнэ.

Анхан шатны шүүх шүүгдэгч М-ийн (хэд хэдэн шүүгдэгчийн хамтран оролцоотой үйлдэгдсэн хэргийн хувьд шүүгдэгч тус бүрийн) үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн ... дугаар зүйлийн ... дэх хэсэгт зааснаар зүйлчилж, Эрүүгийн хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн үндэслэлийг тусгана.

Анхан шатны шүүхээс шүүгдэгч М-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн ... дүгээр зүйлийн ... дэх хэсэгт зааснаар ... жилийн хорих ял шийтгэсэн нь түүний үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирч байгаа талаар гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигтай холбон үндэслэл бүхий тайлбар хийнэ.

Шүүгдэгч М-ийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанарыг харгалзан оногдуулсан хорих ялыг хаалттай, нээлттэй хорих байгууллагад эдлүүлэхээр тогтоосон нь үндэслэлтэй эсэх талаар дүгнэнэ.

Өмгөөлөгч Ч нь "...” гэсэн агуулга бүхий давж заалдах гомдол гаргажээ.

Өмгөөлөгчийн хэргийн үйл баримтын талаар гаргасан давж заалдах гомдолд хариу өгөхдөө, нотлох баримтад тулгуурлан тухайн гэмт хэргийн нотлогдсон байдлын талаар дүгнэнэ. Ингэхдээ, өмгөөлөгчийн саналыг няцаан үгүйсгэсэн үндэслэлийг бичнэ.

Өмгөөлөгчийн хэргийн зүйлчлэлтэй холбоотой давж заалдах гомдолд хариу өгөхдөө, эхлээд тухайн гэмт хэргийн үндсэн шинжийн ойлголтыг гаргаж ирэх, дараа нь өрсөлдөх хэмжээний хоорондын ялгаа, онцлогийг гаргаж, аль зүйлчлэлээ зөв болохыг тайлбарлана.

Шүүгдэгч М-ийн өмгөөлөгч Ч-гийн гаргасан давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож, шийтгэх тогтоолыг хэвээр үлдээх талаар дүгнэлт оруулна.

Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох болон тогтоох хэсэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.7, 36.8 дугаар зүйлд заасны дагуу бичигдээгүй байвал энэ талаар заавал зааж, цаашид анхаарч ажиллахыг тэмдэглэнэ.

Тухайлбал, анхан шатны шүүх шийтгэх тогтоолынхоо тодорхойлох хэсэгт, шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэг, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтын агуулга, хохирлын хэр хэмжээ, хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал, эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний үндэслэл, ял эдлүүлэх хорих байгууллагын дэглэм заасан үндэслэл, зүйлчлэл өөрчилсөн үндэслэл, хохирол хор уршигтай холбоотой нэхэмжлэлд хийсэн дүгнэлт, гэмт хэрэг үйлдэж олсон орлого, хөрөнгийг хэрхэн шийдвэрлэх талаарх үндэслэл, эд мөрийн баримтыг хэрхэн шийдвэрлэх талаар анхан шатны шүүх дүгнэлт хийгээгүй байвал энэ талаар зааж, анхан шатны шүүх шийтгэх тогтоолдоо уг асуудлуудын талаар нэг бүрчлэн дүгнэлт хийдэг болгож хэвшүүлэхэд чиглэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. ... дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаартай шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгч М-ийн өмгөөлөгч Ч-гийн гаргасан давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгохыг заана.

2. Анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн гэж үзвэл энэхүү магадлалыг

гардуулсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор хэргийн оролцогч хяналтын журмаар гомдол гаргах, прокурор эсэргүүцэл бичих эрхтэйг дурдана.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

ШҮҮГЧ

ШҮҮГЧ

## Загвар 2 (Магадлалаар шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулах)

### МАГАДЛАЛ

...-д холбогдох эрүүгийн  
хэргийн тухай

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч ... даргалж, шүүгч ..., ... нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн шүүх хуралдааны танхимд нээлттэй (хаалттай) хийсэн шүүх хуралдаанд:

прокурор ...,

хохилогч ...,

шүүгдэгч ...,

өмгөөлөгч ...,

нарийн бичгийн дарга ... нарыг оролцуулан,

... дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч .... даргалж, шүүгч .... нарын бүрэлдэхүүнтэй хийсэн шүүх хуралдааны ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаартай шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч шүүгдэгч М-ийн өмгөөлөгч Ч-гийн гаргасан давж заалдах гомдлоор шүүгдэгч М-д холбогдох ... дугаартай эрүүгийн хэргийг... оны ... дугаар сарын ...-ны өдөр хүлээн авч, шүүгч М-ийн илтгэснээр хянан хэлэлцэв.

... овгийн М-ийн О, ... оны ... дугаар сарын ...-ны өдөр ... аймагт төрсөн, ... нас, хүйс, боловсрол, мэргэжил, эрхэлсэн ажил, ам бүл, ... нарын хамт Б дүүргийн ... дүгээр хороо,... дугаар байрны ... тоотод оршин суух бүртгэлтэй, хэрэгт ач холбогдол бүхий биеийн байцаалтын талаарх бусад мэдээлэл, ял шийтгэлгүй, (РД: ...);

Урд ял шийтгүүлж байсан бол аль шүүхийн, хэдэн оны, хэдэн сарын, хэдний өдрийн хэдэн тоот шийтгэх тогтоолоор ямар ялаар шийтгүүлж байсныг бичнэ.

Холбогдсон хэргийн үйл баримтыг яллах дүгнэлт, анхан шатны шүүхээс тогтоосон хэргийн үйл баримтын хүрээ хязгаараас гаргахгүйгээр энэ хэсэгт тусгана.

С дүүргийн прокурорын газраас: М-ийн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн ... дүгээр зүйлийн ... дэх хэсгийн ... дэх заалтад зааснаар зүйлчлэн яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлжээ.

С дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх: Гэм буруутай байдлыг тогтоосон, Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, хэсгээр ял оногдуулсан, ялыг нэмж нэгтгэсэн, дэглэм тогтоосон, цагдан хоригдсон хоног тооцсон, хохирол гаргуулахаар шийдсэн, гэмт хэрэг үйлдэж олсон орлого, хөрөнгө зэргийг улсын орлого болгосон, хөрөнгө битүүмжилсэн, эд мөрийн баримтыг шийдвэрлэсэн зэрэг заалтуудыг болон бусад шаардлагатай гэж үзсэн заалтуудыг оруулах.

Шүүгдэгч М-ийн өмгөөлөгч Ч давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: "... Давж заалдах гомдлын гол санаануудыг товчлон оруулах. Гэхдээ гомдол гаргасан оролцогчийн гомдлын үндэслэл, бүтэц, агуулгыг алдагдуулж болохгүй. Хэрвээ алдагдахаар байвал товчлох шаардлагагүй.

Шүүх хуралдаанд оролцож байгаа оролцогч нарын тайлбарыг оруулна.

Прокурорын шүүх хуралдаанд гаргасан дүгнэлтийг тусгана.

## ТОДОРХОЙЛОХ НЬ:

Давж заалдах шатны шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэгт зааснаар давж заалдах гомдолд заасан асуудлаар хязгаарлахгүйгээр хэргийн бүх ажиллагаа, шийдвэрийг бүхэлд нь хянасан байдлыг оруулна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих асуудлуудыг хангалттай шалгаж тодруулсан, хэрэгт авагдсан нотлох баримтын хүрээнд хэргийг эцэслэн шийдвэрлэсэн нь үндэслэлтэй болсныг заана.

Хэргийн үйл баримтыг тогтооход үндэслэл болсон нотлох баримтуудыг цуглуулах, бэхжүүлэх, үнэлэх шатанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шаардлагыг зөрчсөн эсэх талаар дүгнэх бөгөөд зөрчсөн тохиолдолд зөрчлийг тодорхой зааж, уг шүүхийн шийдвэрт хэрхэн нөлөөлж байгааг заана.

Давж заалдах шатны шүүхээс хэргийн үйл баримтыг өөрчилсөн тохиолдолд хууль зүйн үндэслэлээ тайлбарлаж, хэргийн үйл баримтыг өөрчлөн тогтоох болсон нотлох баримтуудын утгыг зааж, харин уг байдлыг үгүйсгэж байгаа нотлох баримтуудыг няцаан үгүйсгэсэн үндэслэлийг бичиж, шинээр тогтоосон үйл баримт нь Эрүүгийн хуульд заасан ямар гэмт хэргийн шинжийг хангаж байгаа талаар дүгнэнэ.

Хэргийн зүйлчлэлийн талаар дүгнэхдээ өрсөлдөх хэмжээний хоорондын ялгаа, онцлогийг гаргаж, аль зүйчлэлээ зөв болохыг тайлбарлана.

Хэд хэдэн шүүгдэгчийн хамтран оролцоотой үйлдэгдсэн хэргийн хувьд шүүгдэгч тус бүрийн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн ... дугаар зүйлийн ... дэх хэсэгт зааснаар зүйлчилснээ Эрүүгийн хуулийг тайлбарлах байдлаар тусгана.

Дээрх анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах үндэслэл нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсгийн алинд хамаарч байгааг заана.

М нь ... (хэд хэдэн шүүгдэгчийн хамтран оролцоотой үйлдэгдсэн хэргийн үйл баримтыг нэгтгэж бичихдээ шүүгдэгч тус бүрийн үйлдэл, оролцоо, хамтран оролцсон хэлбэрийг тусгана) гэмт хэрэг үйлдсэн болох нь:

хохилогч Ц-гийн “...” (хх 24) гэсэн,

гэрч А-гийн (1 хх 35-36) гэсэн тус тус мэдүүлгүүд, (мэдүүлгийн гол хэсгийг товч оруулна)

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн “...” гэсэн ... дугаартай шинжээчийн дүгнэлт (1 хх 81-82),

хэргийн газрын үзлэг хийсэн тэмдэглэл, гэрэл зургийн үзүүлэлтүүд (1 хх 10), эд мөрийн баримт (1 хх 21) зэрэг хэрэгт цуглуулж, бэхжүүлсэн, анхан шатны шүүхийн шүүх хуралдааны хэлэлцүүлгээр хэлэлцэгдсэн хэрэгт хамааралтай, ач холбогдол бүхий нотлох баримтуудаар нотлогдсон байдлыг тусгана.

Дээрх байдлаар нотлох баримтыг заахдаа, бүх нотлох баримтыг оруулахгүйгээр хэрэгт хамааралтай, ач холбогдол бүхий гол нотлох баримтыг бичих бөгөөд ингэхдээ, тухайн нотлох баримтын агуулгыг өөрчлөхгүйгээр гол хэсгийг оруулна.

Харин бусад нотлох баримтын хувьд, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтуудыг няцаан үгүйсгээгүй, харин давхар нотолж байгаа талаар тайлбарлана.

Олон үйлдэлтэй залилан, хулгай, дээрмийн гэмт хэргийн нотлох баримтыг хохирогч А (1 хх 22), Б (2 хх 36), В (3 хх 23), гэрч А (1 хх 22), Б (2 хх 36), В (3 хх 23) нарын мэдүүлэг, хэргийн газрын үзлэг хийсэн тэмдэглэл, гэрэл зургийн үзүүлэлтүүд (1 хх 10, 2хх 7, 3хх 55), эд мөрийн баримт (1 хх 21, 2 хх 6, 3 хх 88) зэрэг хэрэгт цуглуулж, бэхжүүлсэн, анхан шатны шүүхийн шүүх хуралдааны хэлэлцүүлгээр хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар нотлогдон тогтоогджээ гэж бичиж болно.

Хэд хэдэн шүүгдэгч гэмт хэрэг хамтран үйлдсэн бол хамтран оролцсон шүүгдэгч тус бүрийн үйлдсэн гэмт хэрэг хэрхэн нотлогдож байгаа талаарх нотлох баримтыг заана.

Хэргийн үйл баримт, зүйлчлэлийг өөрчилсөн тохиолдолд шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохируулан үндэслэл бүхий ял шийтгэл оногдуулна.

Шүүгдэгч М-ийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанарыг харгалзан оногдуулсан хорих ялыг хаалттай, нээлттэй хорих байгууллагад эдлүүлэхээр тогтооно.

Өмгөөлөгч Ч нь "...” гэсэн агуулга бүхий давж заалдах гомдол гаргажээ.

Өмгөөлөгчийн хэргийн үйл баримтын талаар гаргасан давж заалдах гомдолд хариу өгөхдөө, нотлох баримтад тулгуурлан тухайн гэмт хэргийн нотлогдсон байдлын талаар дүгнэнэ. Ингэхдээ, өмгөөлөгчийн саналыг няцаан үгүйсгэсэн, хүлээн авсан үндэслэлийг бичнэ.

Шүүгдэгч М-ийн өмгөөлөгч Ч-гийн гаргасан давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгосон, эсхүл хүлээн авсан, шийтгэх тогтоолд дээр дурдсан үндэслэлээр өөрчлөлт оруулж байгааг тусгана.

Өмгөөлөгчийн хэргийн зүйлчлэлтэй холбоотой давж заалдах гомдолд хариу өгөхдөө, эхлээд тухайн гэмт хэргийн үндсэн шинжийн ойлголтыг гаргаж ирэх, дараа нь өрсөлдөх хэмжээний хоорондын ялгаа, онцлогийг гаргаж, аль зүйлчлэлээ зөв болохыг тайлбарлана.

Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох болон тогтоох хэсэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.7, 36.8 дугаар зүйлд заасны дагуу бичигдээгүй байвал энэ талаар заавал зааж, цаашид анхаарч ажиллахыг тэмдэглэнэ.

Тухайлбал, анхан шатны шүүх шийтгэх тогтоолынхоо тодорхойлох хэсэгт, шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэг, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтын агуулга, хохирлын хэр хэмжээ, хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал, эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний үндэслэл, ял эдлүүлэх хорих байгууллагын дэглэм заасан үндэслэл, зүйлчлэл өөрчилсөн үндэслэл, хохирол хор уршигтай холбоотой нэхэмжлэлд хийсэн дүгнэлт, гэмт хэрэг үйлдэж олсон орлого, хөрөнгийг хэрхэн шийдвэрлэх талаарх үндэслэл, эд мөрийн баримтыг хэрхэн шийдвэрлэх талаар анхан шатны шүүх дүгнэлт хийгээгүй байвал энэ талаар зааж, анхан шатны шүүх шийтгэх тогтоолдоо уг асуудлуудын талаар нэг бүрчлэн дүгнэлт хийдэг болгож хэвшүүлэхэд чиглэнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.4, 1.5 дэх заалтыг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. ... дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаартай шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт нэмэлт заалт, эсхүл аль заалтыг хэрхэн өөрчилснөө тодорхой заах байдлаар өөрчлөлт оруулна.

2. Шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн бусад заалтыг хэвээр үлдээж, шүүгдэгч М-ийн өмгөөлөгч Ч-гийн гаргасан давж заалдах гомдлын ... гэсэн хэсгийг хэрэгсэхгүй болгох, эсхүл хүлээн авсныг заана.

3. Анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн гэж үзвэл энэхүү магадлалыг гардуулсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор хэргийн оролцогч хяналтын журмаар гомдол гаргах, прокурор эсэргүүцэл бичих эрхтэйг дурдана.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

ШҮҮГЧ

ШҮҮГЧ

Загвар 3 (Магадлалаар шийтгэх тогтоол, хэргийг прокурорт буцаасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хүчингүй болгох)

МАГАДЛАЛ

...-д холбогдох эрүүгийн хэргийн тухай

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч ... даргалж, шүүгч ..., ... нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн шүүх хуралдааны танхимд нээлттэй (хаалттай) хийсэн шүүх хуралдаанд:

прокурор ...,

хохилогч ...,

шүүгдэгч...,

өмгөөлөгч ...,

нарийн бичгийн дарга ... нарыг оролцуулан,

... дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч .... даргалж, шүүгч .... нарын бүрэлдэхүүнтэй хийсэн шүүх хуралдааны ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаартай шийтгэх тогтоол, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг эс зөвшөөрч шүүгдэгч М-ийн өмгөөлөгч Ч-гийн гаргасан давж заалдах гомдлоор, эсхүл эсэргүүцлээр шүүгдэгч М-д холбогдох ... дугаартай эрүүгийн хэргийг ... оны ... дугаар сарын ...-ны өдөр хүлээн авч, шүүгч М-ийн илтгэснээр хянан хэлэлцэв.

... овгийн М-ийн О, ... оны ... дугаар сарын ...-ны өдөр ... аймагт төрсөн, ... нас, хүйс, боловсрол, мэргэжил, эрхэлсэн ажил, ам бүл, ... нарын хамт Б дүүргийн ... дүгээр хороо, ... дугаар байрны ... тоотод оршин суух бүртгэлтэй, хэрэгт ач холбогдол бүхий биеийн байцаалтын талаарх бусад мэдээлэл, ял шийтгэлгүй, (РД: ...);

Урд ял шийтгүүлж байсан бол аль шүүхийн, хэдэн оны, хэдэн сарын, хэдний өдрийн хэдэн тоот шийтгэх тогтоолоор ямар ялаар шийтгүүлж байсныг бичнэ.

Холбогдсон хэргийн үйл баримтыг яллах дүгнэлт, анхан шатны шүүхээс тогтоосон хэргийн үйл баримтын хүрээ хязгаараас гаргахгүйгээр энэ хэсэгт оруулна.

С дүүргийн Прокурорын газраас: М-ийн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн ... дүгээр зүйлийн ... дэх хэсгийн ... дэх заалтад зааснаар зүйлчлэн яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлжээ.

С дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх: Гэм буруутай байдлыг тогтоосон, Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, хэсгээр ял оногдуулсан, ялыг нэмж нэгтгэсэн, дэглэм тогтоосон, цагдан хоригдсон хоног тооцсон, хохирол гаргуулахаар шийдсэн, гэмт хэрэг үйлдэж олсон орлого, хөрөнгө зэргийг улсын орлого болгосон, хөрөнгө битүүмжилсэн, эд мөрийн баримтыг шийдвэрлэсэн зэрэг заалтуудыг болон бусад шаардлагатай гэж үзсэн заалтуудыг оруулна.

Хэргийг прокурорт буцаасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолтой хэргийн хувьд, захирамж, тогтоолд тусгагдсан хэргийг буцаах үндэслэлүүдийг тусгана.

Шүүгдэгч М-ийн өмгөөлөгч Ч давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: "... Давж заалдах гомдлын гол санаануудыг товчлон оруулах. Гэхдээ гомдол гаргасан оролцогчийн гомдлын үндэслэл, бүтэц,

агуулгыг алдагдуулж болохгүй. Хэрвээ алдагдахаар байвал товчлох шаардлагагүй.

Прокурор Р тус шүүх хуралдаанд гаргасан дүгнэлтдээ: "...” гэв.

#### ТОДОРХОЙЛОХ НЬ:

Давж заалдах шатны шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэгт зааснаар давж заалдах гомдолд заасан асуудлаар хязгаарлахгүйгээр хэргийн бүх ажиллагаа, шийдвэрийг бүхэлд нь хянасан байдлыг тусгана.

Хэргийг прокурорт буцаасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хүчингүй болгосон тохиолдолд

Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд заасан хэргийг прокурорт буцаах үндэслэлүүдтэй холбоотой мөрдөн шалгах ажиллагаа хэрэгт бүрэн хийгдсэн, хэрэгт цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтуудад үндэслэн гэм буруугийн талаар дүгнэлт хийх боломжтой байдлыг заана.

Түүнчлэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдлын талаар шалгасан болохыг,

мөн хуулийн 16.15 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэгт зааснаар нотлох баримтыг харьцуулан шинжлэн судлах, нотлох баримтын эх сурвалжийг магадлах аргаар шалгаж, хэрэгт цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримт нь хэрэг хамааралтай, ач холбогдолтой эсэхийг хянаж үнэлэх байдлаар шийдвэрлэх,

мөн хуулийн 1.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хэргийн бодит байдлыг мэтгэлцээний үндсэн дээр тогтоох боломжтой байгааг,

мөн хуулийн 34.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт, шүүгдэгчийн хувьд прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн хүрээнд явагдана гэж заасан зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой болохыг тус тус заана.

Шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг прокурорт болон анхан шатны шүүхээр хэлэлцүүлэхээр буцаасан тохиолдолд

Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн талаарх хууль зүйн үндэслэлийг онолын үндэслэлтэй гаргах бөгөөд уг байдал нь хэрэгт зайлшгүй нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийх, эсхүл анхан шатны шүүхээр хэлэлцүүлэх тус тус нөхцөл болж байгаа байдлыг гаргаж, хэргийг прокурорт, эсхүл шүүхэд буцаах үндэслэл болсныг тайлбарлана.

Дээрх байдал нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.7 дугаар зүйлийн аль хэсэгт хамаарч байгаа талаар бичнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих асуудлуудыг хангалттай шалгаж тодруулаагүй үндэслэлээр шийтгэх тогтоолыг хүчингүй болгосон бол уг ажиллагааг мөрдөн байцаалтын шатанд хийж гүйцэтгүүлэх, эсхүл анхан шатны шүүхийн хэлэлцүүлгээр тодруулан шийдвэрлэх боломжтойг тус тус заана.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчсөн байдал нь хэргийг прокурорт буцаах, эсхүл анхан шатны шүүхээр хэлэлцүүлэх үндэслэл болж байгаа талаар тодорхой заана.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ноцтой зөрчсөн байдал нь 39.8 дугаар зүйлийн аль заалтад хамаарч байгааг тайлбарлана.

Шүүхийн шийдвэрт заасан үндэслэл нь хэргийн бодит байдалтай нийцээгүй гэсэн үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох тохиолдолд

нотлох баримтад үндэслэж, тухайн гэмт хэргийн үндсэн шинжийн талаарх онолын ойлголттой холбоотой тайлбар хийнэ.

Ингэхдээ, нотлох баримтыг хэрхэн үнэлэхийг болон хэргийг хэрхэн шийдвэрлэхийг заах байдлаар чиглүүлэхгүй бөгөөд хэргийн үйл баримт, нотлох баримтыг эцэслэн дүгнэж болохгүй.

Өмгөөлөгчийн давж заалдах гомдол, прокурорын эсэргүүцлийн аль хэсгийг, эсхүл бүхэлд нь хүлээн авсныг, эсхүл өмгөөлөгчийн давж заалдах гомдол, прокурорын эсэргүүцэлд хууль зүйн дүгнэлт хийгээгүй байдлыг заана.

Иймд шийтгэх тогтоолыг (шүүхийн шийдвэр) хүчингүй болгож, хэргийг прокурорт, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт, эсхүл яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шатнаас болон шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр буцааж байгааг тодорхой заана.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2, 1.3 дахь заалтыг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.... дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаартай шийтгэх тогтоол, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хүчингүй болгож, хэргийг прокурорт болон шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт, эсхүл яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шатнаас болон шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр буцааж байгааг тодорхой заана.

2.Шүүгдэгчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэргийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт, эсхүл яллагдагчийг шүүхэд шилжүүлэх хүртэл, шүүх хуралдаанаар хэлэлцтэл, хэргийг прокурорт очтол хэвээр үргэлжлүүлэх эсэхийг заана.

3.Анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн гэж үзвэл энэхүү магадлалыг гардуулсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор хэргийн оролцогч хяналтын журмаар гомдол гаргах, прокурор эсэргүүцэл бичих эрхтэйг дурдана.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

ШҮҮГЧ

ШҮҮГЧ

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны  
2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн  
29 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

## ХЯНАЛТЫН ШАТНЫ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

1. Хяналтын шатны шүүхийн тогтоолыг боловсруулахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Гучин зургадугаар бүлэгт заасан шүүхийн шийдвэр гаргахад тавигддаг нийтлэг шаардлага, түүнчлэн уг хуулийн 40.8 дугаар зүйлд заасан хяналтын шатны шүүхийн шийдвэр гаргахад тавигддаг тусгайлсан шаардлага нэгэн адил хамаарна.

2. Хяналтын шатны шүүхийн тогтоол нь төрийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандарт, баримт бичгийн бүрдэл, хэлбэрийн шаардлагад нийцсэн байх төдийгүй, шийдвэрлэж байгаа асуудлын агуулга, утга санааг бүрэн зөв илэрхийлсэн, хууль зүйн үг хэллэг ашигласан, товч тодорхой, ойлгомжтой, логик дэс дараалалтай, үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаа мадаггүй бичигдсэн байх ёстой.

3. Хяналтын шатны шүүхэд ирүүлсэн гомдол, эсэргүүцлийг Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж, эрх олгогдоогүй оролцогч гаргасан, эсхүл хуулиар тогтоосон хугацаа хэтрүүлж гаргасан, эсхүл Шүүхийн тухай хуулийн 25.7 дугаар зүйлийн 25.7.5 хэсэгт заасан, мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас өөр үндэслэлээр гаргасан тохиолдолд хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэхээс татгалзсан талаар тогтоол гаргана.

4. Хяналтын шатны шүүхэд ирүүлсэн гомдол, эсэргүүцлийн агуулга нь анхан болон давж заалдах шатны шүүх эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн үндэслэлд хамаарч байна гэж танхимын шүүгчдийн дөрөв, түүнээс дээш шүүгчид санал гаргасан тохиолдолд хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар тогтоол гаргана.

5. Тодорхой баримт бичиг, баримтат мэдээллүүдийг хянан дүгнэж, үйл баримтыг сэргээн тогтоож, түүнд эрх зүйн дүгнэлт хийж буй эрх бүхий хүмүүсийн шийдвэр, тэдгээрийн үндэслэлийг шатлан хянаж, үүнтэй холбоотойгоор өөр өөр баримт бичигт үндэслэн, тэдгээрийг ахин дахин дурдахад хүрдэг онцлогоос хамаарч шүүхийн шийдвэрийн бичвэрт догол мөр, үечлэл ашиглах, түүнчлэн тоо буюу үсгээр дугаарлах нь тухайн баримт бичиг тодорхой, ойлгоход хялбар байх үүднээс чухал ач холбогдолтой тул тогтоолын санааг бүлэглэн хувааж дугаарлах хэрэгтэй. Шийдвэрийг догол мөрөөр дугаарласнаар шүүхийн дүгнэлт агуулсан хэсэг бүрийн талаар талууд санал илэрхийлэх, дүгнэлт өгөх, түүнийг хянан үзэж буй этгээд төвөггүй олоход хялбар болгож, шийдвэрийн маргаан дагуулж буй хэсгийн талаар андуурал гарахаас сэргийлэхээс гадна сургалт, судалгааны эргэлтэд оруулах үед шийдвэрийн хэсэг бүрт хүрч ажиллах боломжийг бүрдүүлэх юм. Өөрөөр хэлбэл, шүүхийн хэргийн талаарх завсрын болон эцсийн дүгнэлтүүдийг бүгдийг талбарын нэгжээр хаягжуулснаар түүнийг хянах тогтолцоог боловсронгуй болгосон гэж ойлгож болно. Шийдвэрийг утга санаа, үндэслэлийг ямагт ил гаргаж тавин шүүмжлэл, няцаалтаар сорьж байхаас бус түүнийг бүтцийн талаас далдалж нуух учир шалтгаан шүүгчид байх ёсгүй.

6.Тогтоолд эрх зүйн онолын ойлголт болон бусад хууль зүйн баримт бичгийн бичвэр, томъёоллыг бүхэлд нь, эсхүл давхардуулан тусгахгүй үүднээс эш татах нь зохимжтой гэж үзсэн бол эшлэлийг тодорхой хийж, тэдгээр баримт бичгийн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх хэрэгтэй. Харин шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон, шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримт нь тогтоолын үндсэн бүрдэл хэсэгт тусгагдсан байх ёстой учир түүнийг эш татаж болохгүй.

7.Хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол нь хэлбэр, бүтцийн хувьд удиртгал, тодорхойлох, тогтоох хэсгүүдээс бүрдэнэ. Эрүүгийн хэргийн талаар гаргасан шийтгэх болон цагаатгах тогтоолын тодорхойлох хэсэг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.7, 36.9 дугаар зүйлд зааснаар шийтгэх, эсхүл цагаатгах хэлбэртэй байна.

#### Нэг.Тогтоолын удиртгал хэсэг

1.1.Хяналтын шатны шүүхээс гаргах тогтоолын удиртгал хэсэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6 дэх хэсэгт заасан зүйлсийг дурдаж бичнэ.

1.2.Тогтоолын удиртгалд дурдагдаж байгаа зүйлс нь холбогдох шийдвэр, баримт бичгийн бүрэн эх бус харин товч агуулгаар тусгагдаж буйг анхаарч, тэдгээрийг товч, тодорхой илэрхийлэх, тогтоол нь эхлэлийн хувьд эмх цэгц муутай, замбараагүй байвал зорилгоо хангахгүйг бодолцон, хэт сунжирч үргэлжилсэн урт өгүүлбэрээс татгалзаж, агуулгаар нь үечлэн, догол мөр хэрэглэдэг бичвэрийн хэлбэрийг сонгох нь зүйтэй.

1.3.Тогтоолын удиртгал хэсэгт шүүгдэгчийн биеийн байцаалтыг бичихдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгайлан заагаагүй боловч тухайн хүний ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, хүйс, оршин суугаа хаяг, боловсрол, мэргэжил, гэр бүлийн байдал, урьд ял шийтгүүлсэн эсэх, хэрэгт ач холбогдол бүхий биеийн байцаалтын талаарх бусад мэдээ, мөн төрийн албан ёсны бүртгэлийн эх сурвалж болж байгаа тухайн хүний регистрийн дугаар зэргийг бичих нь зүйтэй.

1.4. Тогтоолын удиртгал хэсэгт шүүгдэгчийн холбогдсон эрүүгийн хэргийн товч агуулга, гэмт хэргийн шинжид хамаарч байгаа үйлдэл, үйл баримтыг ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэн бичиж, тухайн хэрэг нь Эрүүгийн хуулийн ямар зүйл, ангид хамаарч байгааг дурдана. Ийнхүү хэргийн товч агуулгыг тодорхойлохдоо яллах дүгнэлтийг хуулбарлахгүйгээр гэмт хэрэг гарсан байдлыг хураангуй боловч бүрэн илэрхийлж бичвэл зохино.

1.5.Түүнээс гадна тогтоолын удиртгал хэсэгт анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн товч агуулга болон магадлалыг эс зөвшөөрч бичсэн хяналтын гомдол, эсэргүүцлийн агуулга, товч үндэслэлийг дурдана.

Мөн тогтоолын удиртгал хэсэгт хяналтын шатны шүүх хуралдаанд оролцсон хэргийн оролцогч нарын гаргасан хууль зүйн дүгнэлтийн товч агуулгыг тусгана.

#### Хоёр.Тогтоолын тодорхойлох хэсэг

2.1. Тогтоолын тодорхойлох хэсэг нь анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр нь хуулийн ёсны бөгөөд үндэслэл бүхий гарсан эсэхийг хянан дүгнэсэн, хяналтын шатны шүүхийн тогтоолын хууль зүйн үндэслэгээ бүхий чухал хэсэг байдаг.

2.1. Хяналтын шатны шүүхээс эрүүгийн хэргийн талаар гаргасан гомдол, эсэргүүцлийн үндэслэлийг хэрхэн дүгнэсэн талаар энд эхэлж бичнэ. Жишээ нь: “Шүүгдэгчийн өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдол үндэслэлтэй. Анхан болон давж заалдах шатны шүүх холбогдох хуулийн зохицуулалтыг зөрүүтэй тайлбарлан хэрэглэсэн байна.” гэх мэт.

Эрх зүйн үндэслэл: Хэргийн оролцогчоос хяналтын журмаар гаргасан гомдлыг хангасан/хангаагүй эрх зүйн үндэслэлийг буюу гомдол гаргагчийн маргаж буй хууль зүйн үндэслэлд дүгнэлт өгнө. Хяналтын журмаар гаргасан гомдлын үндэслэлээс хамаарч эрх зүйн үндэслэл хэсэг нь дараах дэд хэсгүүдтэй (бүгд эсхүл зарим нь) байж болно:

2.1.1.Тухайн хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой онолын болон харьцуулсан судалгааны хэсэг;

2.1.2.Тухайн асуудалтай холбоотой Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар байгаа эсэх, байгаа бол хэрхэн тайлбарласныг (эшлэл хийн) тусгах;

2.1.3.Ижил төстэй хэргийг өмнө шийдвэрлэсэн байдал (эшлэл заан, дүгнэх байдлаар);

2.1.4.Анхан болон давж заалдах шатны шүүх холбогдох хуулийг хэрхэн зөрүүтэй байдлаар тайлбарласан;

2.1.5.Анхан, давж заалдах шатны шүүх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас яаж өөрөөр тайлбарлан хэрэглэсэн;

2.1.6.Тухайн хэрэг маргааныг ямар онолын үндэслэл, харьцуулсан судалгаа, Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг харгалзан үзэж, холбогдох хуулийг хэрхэн тайлбарлан хэрэглэж (хууль тайлбарлах аргаар), ямар эрх зүйн эцсийн үр дагаварт хүрснээ тодорхойлж, түүнийг анхан болон давж заалдах шатны шүүх яаж зөрүүтэй тайлбарлан хэрэглэсэн, аль нь зөв болохыг, эсхүл анхан, давж заалдах шатны шүүх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарласан нь зөв/буруу болохыг дүгнэж, шийдвэр/магадлалыг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэнэ.

Харин хэргийн оролцогчоос “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн” үндэслэлээр хяналтын журмаар гаргасан гомдлыг хянан хэлэлцсэн бол тогтоолын Тодорхойлох хэсэгт тухайн процессын зөрчил нь ямар учраас шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэж үзэж байгааг тайлбарлаж, шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, анхан/давж заалдах шатны шүүхэд буцаах үндэслэлтэй болохыг дүгнэнэ.

Хянавал хэсгийн агуулга нь бүхэлдээ тогтоолын тодорхойлох хэсэгт заасан хэргийн оролцогчийн гаргасан гомдолд хариу өгөх байдлаар бичигдэнэ./ЭХХШТХ-ийн 40.5 дугаар зүйлийн 5 заасантай нийцэхгүй байгаа эсэх/

#### Гурав.Тогтоолын тогтоох хэсэг

3.1.Тогтоолын тогтоох хэсгийн заалтууд удиртгал болон тодорхойлох хэсгийн заалтуудтай харилцан уялдаа холбоотой, утга агуулгын хувьд зөрчилгүй, ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар томъёологдсон байх шаардлагатай.

3.2.Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр хууль ёсны ба үндэслэлтэй гарсан бөгөөд хяналтын гомдол, эсэргүүцэлд бичигдсэн үндэслэл тогтоогдохгүй байна гэсэн дүгнэлт хийгдсэн тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.8 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, хяналтын гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тухай тогтоох хэсэгт заана.

3.3. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрүүд бүхэлдээ, эсхүл аль нэг шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болж чадаагүй байна гэсэн дүгнэлт хийсэн тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.8 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт заасныг удирдлага болгон тухайн шийдвэрүүдийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тухай тогтоох хэсэгт заана.

3.4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 34.7 дугаар зүйлийн 6.2-т заасан үндэслэл тогтоогдвол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.8 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт заасныг удирдлага болгон анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг прокурорт, эсхүл дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаахаар шийдвэрлэсэн тухай тогтоох хэсэгт заана.

3.5. Анхан болон давж заалдах шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийн хэм хэмжээ, түүний агуулгыг буруу тайлбарлаж хэрэглэсэн үндэслэл тогтоогдвол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.8 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэгт заасныг удирдлага болгон анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр дэх хэргийн зүйлчлэл, ял шийтгэлийг хөнгөрүүлсэн өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн тухай тогтоох хэсэгт заана.

3.6. Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэргийг хянан хэлэлцэх үед Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан үндэслэл тогтоогдвол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.8 дугаар зүйлийн 1.5 дэх хэсэгт заасныг удирдлага болгон гомдол, эсэргүүцлийг хэлэлцэлгүй орхиж шийдвэрлэсэн тухай тогтоох хэсэгт заана.

3.7. Хяналтын журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийг бүхэлд, эсхүл зарим хэсгийг хүлээн авсан, мөн хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тухай заана. Түүнээс гадна хэргийг прокурорт, эсхүл шүүхэд очтол шүүгдэгчид авсан таслах сэргийлэх арга хэмжээний талаар тогтоох хэсэгт заана.

3.8. Шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна хэргийг хэрэгсэхгүй болгоход баримталбал зохих Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтыг удирдлага болгоно.


3.9. Хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэрэгт холбогдсон хүнийг цагаатгасан үндэслэл, түүнд авсан таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгосон тухай заалт, мөн иргэний нэхэмжлэл ба эд хөрөнгө хурааж болзошгүй байдлыг хангах талаар арга хэмжээ авагдсан бол түүнийг хүчингүй болгосон, хохирлоо төлүүлэхээр нэхэмжлэл гаргах эрх, шүүхэд хандах хугацаа болон шүүхийн харьяаллын тухай заалтыг тогтоох хэсэгт бичнэ.

3.10. Түүнчлэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж байгаа бол тухайн баримт бичгийн бичвэр бүрийг дахин давтаж, хэт нуршихаас зайлсхийж, шүүхийн шийдвэрт орж буй өөрчлөлтийг агуулгын хувьд тодорхой, товч дурдаж заана.

3.11. Тогтоолын тогтоох хэсгийн төгсгөлд хяналтын шатны шүүхийн тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх ба уг тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдана.

-----oOo-----

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны  
2021 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн  
09 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт



## ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр боловсруулахад дараах аргачлалыг баримтлахыг зөвлөж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.1-т зааснаар шүүхийн шийдвэр удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсгээс бүрдэнэ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарах шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол мөн адил бүтэц, хэлбэртэй байна.

### Нэг.Шийдвэрийн удиртгал хэсэгт

1.1.Удиртгал хэсэгт шүүхийн ямар шийдвэрийг хэзээ, хаана, аль шүүх гаргаж байгаа, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогчийг нэрлэн заана.

“Хэзээ” гэдэгт шүүх хуралдаан хэдий хугацаанд үргэлжилсэн гэдгээс үл хамаараад Монгол Улсын нэрийн өмнөөс шүүхийн шийдвэрийг танилцуулан сонсгосон өдрийг ойлгож, шийдвэрийг огноолно. Жишээ нь: “2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр” гэж бүтэн бичнэ.

“Хаана” гэдэгт шүүх хуралдааныг явуулж, шүүх шийдвэрээ гаргасан газар, шүүх хуралдааны танхимыг хэлнэ. Бүх шатны шүүх хуралдаан нээлттэй явагдах зарчимтай тул “нээлттэй” явагдсан талаар бичих шаардлагагүй бөгөөд харин хуульд зааснаар хаалттай явагдсан бол энэ талаар тусгана.

“Ямар шүүх” гэдэгт хэргийг хянан шийдвэрлэж буй шүүхийг Монгол Улсын Шүүх байгуулах тухай хуулиар байгуулагдсан нэрээр тусгана.

“Шүүх бүрэлдэхүүн болон шүүгч” гэдэгт тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх бүрэлдэхүүн болон шүүгчийн нэрийг эцэг (эхийн) нэрийн эхний үсгийн хамт бичнэ.

Хэргийн оролцогчид буюу нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийг нэрлэн заана. Хэргийн оролцогч-иргэний нэр болон эцэг/эхийн нэрийг иргэний үнэмлэхэд бичигдсэнээр шийдвэрт заана. Гадаад улсын иргэн бол иргэний харьяаллыг, харьяалалгүй хүн бол энэ талаар тусгана. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний нэрийг паспорт, паспортыг орлох баримт бичиг дээр тусгасан байдлаар бичнэ. Гадаадын иргэний нэрийг галиглахгүй, монгол хэл дээр хөрвүүлэхгүй. Жишээ нь, БНХАУ-ын иргэний “Ni Run Gua” гэх нэрийг “Нарангуа” гэж бичихгүй.

Хуулийн этгээд бол оноосон нэрийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байдлаар нь бичнэ. Жишээ нь: “...” ХХК, “...” УТҮГ, “...” ТӨААТҮГ, “...” банк” ХХК, “...” LTD гэх мэт. Хуулийн этгээдийн нэрийг гэрчилгээнд тусгасан байдлаар заахдаа итгэмжлэлгүй төлөөлөх эрхтэй этгээдийн нэрийг мөн бичнэ.

Шүүх хуралдаанд оролцогчийн нэрийг эцгийн/эхийн овгийн эхний үсгийн хамт (“Н.Амарзаяа” гэж) бичнэ. Түүнчлэн, хэргийн оролцогч, шүүх хуралдааны оролцогч шүүх хуралдаанд цахимаар оролцсон бол тэр талаар тусгана. Мөн шүүх хуралдаанд орчуулагч, хэлмэрч оролцсон бол нэрийг нь бичнэ.

### Хоёр.Шийдвэрийн тодорхойлох хэсэгт

2.1.Шийдвэрийн тодорхойлох хэсэг нь хэргийн оролцогчоос тухайн хэргийн талаар гаргаж буй бүх мэдээллийг агуулсан байх учиртай. Тиймээс энэ хэсэгт нэхэмжлэгч, хариуцагч, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийн тайлбараас гадна шүүхэд хэргийн оролцогчийн гаргаж өгсөн нотлох баримт болон

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүхийн бүрдүүлсэн нотлох баримтыг нэрлэн заана.

2.2.Тодорхойлох хэсгийн хоёр дахь ач холбогдол нь шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгийн суурь нь болдог. Иймд шийдвэрийн эрх зүйн үндэслэл нь тодорхойлох хэсэгт тусгагдсан бодит нөхцөл байдалд тулгуурласан байх ёстой. Тодорхойлох хэсгийг боловсруулахдаа дараах дарааллыг баримтална. Үүнд:

а.Нэхэмжлэлийн үндэслэл: нэхэмжлэгчээс мэдүүлсэн маргааны үйл баримтын агуулга, нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлийг бичнэ.

б.Хариуцагчийн татгалзал/тайлбар: нэхэмжлэлийн үндэслэлийг үгүйсгэж буй татгалзал, тайлбар бүрийг тодорхой тусгана.

в.Сөрөг нэхэмжлэл, түүний үндэслэл: хэрэв хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргасан бол түүний үндэслэл, шаардлагыг бичнэ.

г.Сөрөг нэхэмжлэлд гаргасан нэхэмжлэгчийн тайлбар, үндэслэл: сөрөг нэхэмжлэлд гаргаж буй нэхэмжлэгчийн татгалзал, тайлбарыг тодорхой бичнэ.

д.Гуравдагч этгээдийн бие даасан шаардлага, тайлбар: бие даасан шаардлагын агуулга, үндэслэлийг тодорхой бичнэ.

е.Гуравдагч этгээдийн бие даасан шаардлага, тайлбарын талаарх зохигчийн байр суурь: зохигчийн байр суурийг товч бичих. Жишээ нь: нэхэмжлэгч гуравдагч этгээдийн бие даасан шаардлагыг зөвшөөрөхгүй, маргасан.

ё.Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт: Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцсон бол түүний дүгнэлтийн агуулгыг тусгана.

ж.Нотлох баримт: Зохигчоос шүүхэд гаргасан нотлох баримт, хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүхийн бүрдүүлсэн баримтыг нэрлэн заана.

2.3.Зохигчийн тайлбарыг товч, ойлгомжтой, логик дараалалд оруулж агуулгыг тусгана.

2.4.Нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлээ нэмэгдүүлсэн, багасгасан, өөрчилсөн, шүүх хуралдаан дээр гаргасан нэхэмжлэл, тайлбар нь “Нэхэмжлэлийн үндэслэл” гэсэн хэсэгт нэг дор тусгагдана. Энэ хэлбэр хариуцагчийн гаргасан тайлбар, үндэслэлд нэгэн адил хамаарна. Зохигчийн төлөөлөгч, өмгөөлөгч бие даасан хэргийн оролцогч биш тул төлөөлөгч, өмгөөлөгчийн байр суурь, санал нь төлөөлүүлж буюу өмгөөлүүлж буй этгээдийн тайлбарт хамт тусгагдана.

#### Гурав.Шийдвэрийн үндэслэх хэсэгт

Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлалыг хэрэглэснээр шүүхийн шийдвэрийн бүтэц, төрөл, агуулга, хэл найруулга, хууль зүйн техник, шүүхийн шийдвэр эшлэхэд тавих шаардлага, талуудын шаардлага, татгалзал, тайлбарт маргаж байгаа үйл баримт болон хууль зүйн үндэслэл бүрд бүрэн дүгнэлт өгөхөд ач холбогдолтой. Үндэслэх хэсэгт дараах дарааллыг баримтлах нь зүйтэй. Үүнд:

3.1.Нэгдсэн үр дүн буюу эхлэл хэсэг: Нэхэмжлэлийг хангах, зарим хэсгийг хангах, бүхэлд нь хэрэгсэхгүй болгох талаар буюу нэхэмжлэлийг хэрхэн шийдвэрлэсэн үр дүнг тусгана. (Жишээ нь: “Нэхэмжлэлийг хангах үндэслэлтэй/хангах үндэслэлгүй гэж үзэв.” гэх мэт.)

Шийдлийг эхэнд нь тусгаснаар дараагийн хэсэгт тухайн шийдэлд хүрсэн үндэслэл буюу шүүхийн эрх зүйн дүгнэлтийг бичнэ.

3.2.Нэхэмжлэлийн үндэслэлт байдал: Энэ хэсэгт нэхэмжлэлийг үндэслэлтэй, эсхүл үндэслэлгүй гэж үзсэн бодит болон хууль зүйн үндэслэлийг дэлгэрэнгүй

тайлбарлана. Тодруулбал, хэрэгт авагдсан, шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэслэл болгосон нотлох баримтыг үнэлж дүгнэсэн байдал буюу шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон эрх зүйн хэм хэмжээ, тэдгээрийг хэргийн бодит нөхцөл байдалд хэрхэн тайлбарлаж хэрэглэсэн тухайгаа тусгана. Үндэслэлт байдал нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

### 3.2.1. Маргааны үйл баримтыг тогтоох хэсэг:

3.2.1.1. Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл, хариуцагчийн татгалзал үндэслэл, гуравдагч этгээдийн байр суурь, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийн шаардлагын агуулга, үндэслэлийг эрх зүйн хувьд дүгнэж, нэхэмжлэлийн шаардлага ойлгомжгүй, эсхүл хууль зүйн үг хэллэгээр илэрхийлээгүй тохиолдолд шүүх хууль зүйн хэллэгээр, ойлгомжтой, товч тусгана. Ингэснээр шүүхээс шийдвэрлэх гэж буй нэхэмжлэлийн шаардлага ойлгомжтой, тодорхой болохын зэрэгцээ шүүх энэ талаар зөв ойлгосон гэдгийг илэрхийлнэ. Шүүх нэхэмжлэлийн (сөрөг) шаардлага тус бүрийн талаар дүгнэлт өгөх үүрэгтэй ба шүүхэд гаргаагүй шаардлага, үндэслэлийн талаар дүгнэлт хийх эрхгүйн зэрэгцээ шаардлагын үндэслэл, зүйлээс өөр үндэслэл, зүйлийг шийдвэрлэх, шаардлагын хэмжээнээс илүү хэмжээгээр шийдвэр гаргах эрх шүүхэд байхгүй болно.

3.2.1.2. Нэхэмжлэлийн хүрээ хязгаарыг тодорхойлсны дараа хэрэгт авагдсан болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн ямар нотлох баримтаар, ямар үйл баримт тогтоогдсон, зохигчийн мэдүүлсэн үйл баримтын аль нь тогтоогдож, үгүйсгэгдсэн талаар дүгнэлт хийнэ. Шүүх хэрэгт байгаа ямар баримтыг хэрхэн үнэлсэн, аль баримтыг үнэлээгүй (шалтгааны) талаар тусгана.

3.2.1.3. Талуудын маргаагүй болон маргасан үйл баримтыг ялгаж, маргааны зүйлийг тодорхойлох.

### 3.3. Эрх зүйн үндэслэлийг тодорхойлох хэсэг:

3.3.1. Зохигчийн хооронд үүссэн эрх зүйн харилцааг тодорхойлох, яагаад тухайн хэм хэмжээг тохирсон гэж үзсэн үндэслэлээ бичих;

3.3.2. Шаардах эрхийг тодорхойлсон хэм хэмжээг сонгож, яагаад тухайн хэм хэмжээг хэрэглэх болсон үндэслэлийг тайлбарлан бичих, ямар нотлох баримтыг үндэслэв гэдгээ бичнэ.

3.4. Зүйлчлэл (субсумц) буюу эрх зүйн үр дагаврыг тодорхойлох хэсэг: Тогтоогдсон үйл баримтад холбогдох хуулийг хэрэглэж, эрх үр дагаврыг нь тодорхойлно.

Шаардах эрхийн урьдчилсан нөхцөл хангагдсан эсэхийг шалгах буюу нэхэмжлэлийн шаардлага, хариуцагчийн татгалзлын аль нь хангасан, аль нь хангаагүй болохыг, нэхэмжлэлийг хэрхэн шийдвэрлэсэн үр дүнг тусгана. (Жишээ нь: Нэхэмжлэгч ажлын хөлс шаардахын тулд ажлын үр дүнг бий болгож, захиалагчид хүлээлгэн өгсөн байх урьдчилсан нөхцөлийг Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн 343.1-д заасан байх тул нэхэмжлэгч энэ талаар нотолсон байх шаардлагатай. Нэхэмжлэгч ажлын үр дүнг хүлээлгэн өгсөн болохоо...баримтуудаар нотолсон тул нэхэмжлэлийг хангах үндэслэлтэй...гэх мэт.)

3.5. Үндэслэх хэсэгт шийдвэрт хүрсэн шүүгчийн эрх зүйн дүгнэлт бүрэн илэрхийлэгдэж тусгагдсан байх ёстой.

3.6. Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцсон бол иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг хэрхэн үзэж буй үндэслэлээ тусгана.

3.7. Шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийг хэрхэн шийдвэрлэснийг товч тусгана.

## Дөрөв.Шийдвэрийн тогтоох хэсэгт

4.1.Шүүхийн шийдвэр нь хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэж буй шүүх эрх мэдлийн акт учир энэ хэсэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5-т зааснаар шийдвэрийн үндэслэх хэсэгт дурдсан дүгнэлтийн үр дагаврыг тусгахаас гадна шүүхийн шийдвэр ойлгомжтой, тодорхой, биелэгдэх боломжтой бүх нөхцөлийг заасан байвал зохино. Тогтоох хэсэг захиран тушаах хэлбэртэй байна.

4.1.1.Тогтоох хэсэгт заавал тусгах зүйл:

а.хэргийг хянан шийдвэрлэхэд баримталсан хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтыг заавал заасан байх;

б.нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэл, гуравдагч этгээдийн бие даасан шаардлага бүрийг шийдвэрлэж, нэхэмжлэлийг хэрхэн хангасан, аль хэсгийг хэрэгсэхгүй болгосон талаар заасан байх;

в.хэд хэдэн нэхэмжлэгч, хэд хэдэн хариуцагч байгаа бол нэхэмжлэгч, хариуцагч тус бүрт холбогдуулан ямар шийдвэр гаргасныг ойлгомжтой тодорхой тусгах;

г.улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал төлүүлэх, эд мөрийн баримтыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх асуудлыг ойлгомжтой, тодорхой тусгаж, хэн ямар үүргийг хэрхэн гүйцэтгэх журмыг хууль баримтлан шийдвэрлэсэн байх;

д.шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсгээ зурж, тамга дарж баталгаажуулсан байна.

4.2.Тогтоох хэсэгт шийдвэрийг биелүүлэх арга, журам, хугацааг зөвхөн шаардлагатай тохиолдолд заана.

4.3.Бусад анхаарах зүйл:

4.3.1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мэтгэлцэх үндсэн дээр хэрэгжүүлнэ гэж заасан боловч уг хуулийн 6.6-д онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хэрэгт мэтгэлцэх зарчим хамаарахгүй гэж заасан. Үүнээс гадна гэр бүлийн маргаан, гомдлоор үүсэх хэрэгт мэтгэлцэх зарчим бүрэн хэрэгждэггүй бөгөөд хуульд заасан тохиолдолд шүүх санаачлагаараа эсвэл шүүх илүү идэвхтэй байр суурийг баримталж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах үүрэгтэй байдаг.

Дээрх тохиолдолд шийдвэрийн үндэслэх хэсэгт тусгах шүүхийн эрх зүйн дүгнэлт өөр өөр онцлогтой байх боловч хууль хэрэглэх аргачлалыг агуулгын хувьд баримтална.

4.3.2.Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зохигч эвлэрсэн, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1-д заасан шүүгчийн захирамж, шүүх хуралдааны явцад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.5-д зааснаар шүүгч захирамж, шүүх тогтоол гаргана.

Энэ нь хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх ажиллагаа бөгөөд хуулийн 74, 75, 106 дугаар зүйлийн 106.5, 106.6-д хуульчлагдсан байна. Мөн хуулийн 74<sup>1</sup>-д зааснаар эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр маргааны талаар талууд эвлэрлийн гэрээ байгуулсан бол шүүгч баталгаажуулж, захирамж гаргана.

Дээрх тохиолдолд эвлэрлийн гэрээ Иргэний хуульд нийцсэн эсэх, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндсөн эсэхийг шүүх хянах үүрэгтэй бөгөөд хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь шийдвэрийн нэгэн адил биелэгдэнэ.

Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь удиртгал, тодорхойлох, үндэслэх, захирамжлах (тогтоох) хэсгээс бүрдэхийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1-д заасан байна. Удиртгал, тодорхойлох хэсэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.2, 118.3-т заасан шаардлага нэгэн адил хамаарна.

Харин “Үндэслэх хэсэг”-т эвлэрлийн гэрээ, хариуцагчийн зөвшөөрөл, нэхэмжлэлийн татгалзлыг тусгаж, энэ нь Иргэний хуульд нийцсэн эсэх, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндсөн эсэхийг шүүхээс дүгнэсэн байна.

Зохигч маргаанаа өөрсдөө шийдвэрлэж байгаа тул “тогтоох” хэсэгт хууль баримтлахгүй бөгөөд нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн, зохигч хэрхэн эвлэрсэн болохыг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгоно. Хэргийг хэрэгсэхгүй болгохдоо захиран тушаах хэлбэрээр заана. Мөн улсын тэмдэгтийн хураамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсгээ зурж, тамга дарж баталгаажуулсан байна.

-----o0o-----

Загвар

ИРГЭНИЙ ХЭРГИЙН  
АНХАН ШАТНЫ ШҮҮХ

ШИЙДВЭР

20... оны ... сарын ...өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

УДИРТГАЛ ХЭСЭГ

..... дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч  
.....даргалж,... (шүүгч .....даргалж, шүүгч .....нарын бүрэлдэхүүнтэй) тус  
шүүхийн шүүх хуралдааны танхимд хийсэн иргэний хэргийн шүүх хуралдаанаар:

Нэхэмжлэгч ...

Хариуцагч:

Гуравдагч этгээд: (бие даасан шаардлага гаргасан, бие даасан шаардлага  
гаргаагүй гуравдагч этгээд)

Нэхэмжлэлийн шаардлага:

Сөрөг нэхэмжлэлийн шаардлага:

Бие даасан гуравдагч этгээдийн шаардлага: ....-ыг хянан хэлэлцэв.

Шүүх хуралдааны оролцогчид:

Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч ...

Хариуцагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч....

Гуравдагч этгээд, түүний төлөөлөгч, өмгөөлөгч...

Иргэдийн төлөөлөгч:

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга:

(Хариуцагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бөгөөд нэхэмжлэгчийн  
хүсэлтээр түүний эзгүйд хэргийг хянан хэлэлцэв.)

ТОДОРХОЙЛОХ нь:

1.Нэхэмжлэгч А нь Б-д холбогдуулан зээлийн гэрээний үүргээ зөрчсөнөөс  
учирсан хохиролд 10,000,000 төгрөг гаргуулахаар нэхэмжлэл гаргасан. Нэхэмжлэгч  
нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. ....

2. .... гэх мэт.

2.Хариуцагч хариу тайлбартаа “... Иймд нэхэмжлэлийг хүлээн  
зөвшөөрөхгүй” гэв.

3.Хариуцагчаас нэхэмжлэгчид холбогдуулан “Талуудын хооронд  
байгуулагдсан зээлийн гэрээг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцуулах” тухай  
сөрөг нэхэмжлэлийг гаргасан. Хариуцагч сөрөг нэхэмжлэлийн үндэслэлээ “.....”

гэж тайлбарласан.

4.Нэхэмжлэгч хариуцагчийн сөрөг нэхэмжлэлд “...” гэсэн тайлбарыг гаргасан.

5.Гуравдагч этгээд Г “...” бие даасан шаардлага гаргасан. Үндэслэлдээ “...” гэнэ.

6.Иргэдийн төлөөлөгч “Хариуцагч гэм хор учруулаагүй, гэм буруугүй.... эсвэл хариуцагч гэм буруутай, гэхдээ хохирлын хэмжээг нягтлах шаардлагатай” гэсэн дүгнэлт гаргажээ.

7.Нэхэмжлэгчээс 2019.09.09-ны өдрийн түрээсийн гэрээ, 1,000,000 төгрөг шилжүүлсэн .....баримтуудыг, хариуцагчаас ....баримтуудыг шүүхэд гаргаж өгсөн.

Хариуцагчийн хүсэлтээр .....баримтуудыг (хх-) шүүх бүрдүүлсэн байна.

#### ҮНДЭСЛЭХ нь:

1. Нэхэмжлэлийг хангах үндэслэлтэй/үндэслэлгүй. Эсхүл “Нэхэмжлэгч А-ын нэхэмжлэлээс 1,000,000 төгрөгийн нэхэмжлэлийг хангаж, 9,000,000 төгрөгийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй гэж үзэв.” гэх мэт.

2. Нэхэмжлэгч дараах үндэслэлээр шаардах эрхээ тодорхойлсон. Үүнд:...

3. Хариуцагч нэхэмжлэлийг дараах үндэслэлээр үгүйсгэсэн. Үүнд:...

4. Хариуцагч сөрөг нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлээ .... тодорхойлсон.

5. Нэхэмжлэгч хариуцагчийн сөрөг нэхэмжлэлийг ..... үндэслэлээр няцаасан.

6. Хэрэгт авагдсан болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн ... нотлох баримтаар дараах үйл баримт тогтоогдож байна.

Зохигчийн хооронд ... -ны өдөр .... гэрээ байгуулагдсан байна... гэх мэт.

7. Талуудын маргааны зүйл нь .... байна. .... талаар маргаагүй байна.

8. Зохигчийн хооронд Иргэний хуулийн....-д зааснаар зээлийн гэрээний харилцаа үүссэн байна...

Нэхэмжлэгч .... учир шаардах эрхтэй байна.

Сөрөг нэхэмжлэлийг Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.3-т заасан хүчин төгөлдөр бус хэлцэлд хамаарахгүй тул сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй... гэх мэт.

9. Иргэдийн төлөөлөгчийн “...” дүгнэлтийг үндэслэлтэй/үндэслэлгүй гэж үзэв.

10. .... хуульд зааснаар тэмдэгтийн хураамжийг .... шийдвэрлэх нь зүйтэй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 115 дугаар зүйлийн 115.2.1., 115.2.2., 115.2.3.-т (аль тохирох заалтыг бичнэ)-д заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:


1. Иргэний хуулийн ...-д заасныг баримтлан нэхэмжлэгч... нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, .... сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Улсын тэмдэгтийн хураамжийг ....

3.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны  
2021 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн  
29 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт



## ИРГЭНИЙ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН МАГАДЛАЛ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал боловсруулахад дараах аргачлалыг баримтлахыг зөвлөж байна.

Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдлын дагуу хэргийг хянан хэлэлцээд “магадлал” гаргана. Магадлал, түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан асуудлаар шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол гаргахад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.2, 118 дугаар зүйлд заасан шаардлагыг нэгэн адил баримтална.

### Нэг.Магадлалын удиртгал хэсэг

1.1.Магадлалыг гаргасан огноо, дугаар, аль давж заалдах шатны шүүхийн шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүхийн ямар шийдвэр, хэний нэхэмжлэлтэй хэнд холбогдох ямар маргаан, давж заалдах шатны шүүх хуралдааны оролцогч, хэний гомдлоор, хэргийг илтгэсэн шүүгчийн нэрийг тус тус тусгана. Иргэн, хуулийн этгээдийн оноосон нэрийг хэрхэн тусгах талаар анхан шатны шүүхийн шийдвэр боловсруулах аргачлалд заасан зөвлөмжийг баримтална.

### Хоёр.Магадлалын тодорхойлох хэсэг

2.1.Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл, хариуцагчийн татгалзал, түүний үндэслэл, сөрөг нэхэмжлэл, сөрөг нэхэмжлэлд гаргасан хариу тайлбар, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийн шаардлагын агуулга, анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулга, давж заалдах гомдлын агуулгыг тусгана. Тодорхойлох хэсэгт дараах дарааллыг баримтална. Үүнд:

а.Эхлэл хэсэг: Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл, хариуцагчийн татгалзал, түүний үндэслэл, (сөрөг нэхэмжлэл, хариу тайлбар), гуравдагч этгээдийн бие даасан шаардлага, тайлбар, иргэдийн төлөөлөгч оролцсон бол дүгнэлтийн агуулгыг тус тус товч тусгана.

б.Процессын түүх: Анхан шатны шүүх хэрхэн шийдвэрлэснийг буюу шийдвэрийн тогтоох хэсгийн агуулга.

в.Давж заалдах гомдлын агуулга: Хэргийн оролцогчоос гаргасан давж заалдах гомдлын үндэслэл бүрийг агуулгаар нь дугаарлан, тусгана.

г.Бусад оролцогчийн байр суурь: Хэргийн бусад оролцогч давж заалдах гомдлыг зөвшөөрч байгаа эсэхийг тусгана.

### Гурав.Магадлалын хянавал хэсэг

3.1.Анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэлтэй эсэх талаарх давж заалдах шатны шүүхийн эрх зүйн дүгнэлт, давж заалдах гомдлыг хангах эсэх талаарх дүгнэлт энэ хэсэгт тусгагдана.

3.1.1.Эхлэл хэсэг буюу хяналтын хүрээг заах: Давж заалдах шатны шүүх хэргийг гомдлын хүрээнд эсвэл хэргийг бүхэлд нь хянан хэлэлцсэн эсэхийг заана.

3.1.2.Нэгдсэн үр дүн: Давж заалдах гомдлыг хэрхэн шийдвэрлэснийг тусгана. Жишээ нь: давж заалдах гомдлыг хангах үндэслэлгүй тул шийдвэрийг

хэвээр үлдээв...давж заалдах гомдлын ...хэсгийг хангаж, ...хэсгийг хангахгүй орхив,...давж заалдах гомдол үндэслэлтэй байх тул шийдвэрт...өөрчлөлт, эсвэл хүчингүй болгов...гэх мэт. Энэ байдлаар товч дүгнээд яагаад ийнхүү шийдвэрлэсэн үндэслэл буюу магадлалын эрх зүйн үндэслэлийг тусгах эрх зүйн ажиллагааны дараагийн шат эхэлнэ.

3.1.3. Эрх зүйн үндэслэл: Энэ хэсэг нь хэргийг гомдлын хүрээнд, эсхүл бүхэлд нь хянаж байгаа эсэхээс хамаарч онцлог бүтэцтэй байна. Хянавал хэсэгт дараах эрх зүйн асуудлууд тусгагдана. Үүнд:

а.анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн эсэх, зохигч мэтгэлцэх эрхээ бүрэн хэрэгжүүлсэн эсэх;

б.анхан шатны шүүх нэхэмжлэлийн (сөрөг нэхэмжлэл) шаардлага, үндэслэл, хариуцагчийн татгалзал, түүний үндэслэл, гуравдагч этгээдийн бие даасан шаардлага, тайлбар, маргааны үйл баримт, маргааны зүйлийг хэрхэн тогтоосон, энэ нь үндэслэлтэй эсэх, зохигчийн хооронд үүссэн эрх зүйн харилцааг зөв тодорхойлсон эсэх;

в.нэхэмжлэгчийн шаардах эрх, шаардах эрхийн урьдчилсан нөхцөлүүд хангагдсан эсэх, шүүх хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн, хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн эсэх;

г.иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг анхан шатны шүүх хэрхэн дүгнэсэн, давж заалдах шатны шүүх хэрхэн үзэж байгаа;

д.давж заалдах гомдлын талаар: ямар үндэслэлээр гомдлыг хангасан, заримыг хангасан, эсвэл хангаагүй талаарх дүгнэлт;

е.шаардлагатай бол улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардлын талаарх дүгнэлт.

Хэргийг бүхэлд нь хянасан бол давж заалдах гомдлоор хязгаарлахгүй, хэргийн бодит болон хууль зүйн үндэслэлд дүгнэлт өгч, анхан шатны шүүх ямар нотлох баримтыг үнэлж чадаагүй, ямар баримтыг үнэлээгүй орхисон, хуулийг хэрхэн буруу тайлбарласан, давж заалдах шатны шүүх хэрхэн залруулж, зөвтгөж байгаа үндэслэлээ тодорхой тусгаж, давж заалдах гомдлыг хэрхэн үзэж байгаа талаар тусгасан байна.

Харин гомдлын хүрээнд хэргийг хянан хэлэлцсэн бол давж заалдах гомдлын үндэслэл бүрт хариу дүгнэлт өгөх байдлаар гомдол үндэслэлтэй эсэхийг дүгнэнэ.

3.2. Анхан шатны шүүхийн шийдвэрийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.1.1-д зааснаар хэвээр үлдээсэн бол гомдлыг хангаагүй үндэслэлийг тусгаж, шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хэрхэн хангасан гэж үзсэн үндэслэлээ хянавал хэсэгт тодорхой тусгана.

3.3. Хуулийн 167.1.2, 167.1.3-т заасны дагуу шийдвэрт хэсэгчлэн буюу бүхэлд нь өөрчлөлт оруулах тохиолдолд шийдвэрийн аль хэсгийг хууль зүйн үндэслэлтэй гэж үзсэн болон аль хэсгийг нотлох баримтыг буруу үнэлсэн, хууль буруу хэрэглэсэн гэж үзсэн, хэрхэн өөрчилж байгаа дүгнэлтийг магадлалд тодорхой тусгана.

Давж заалдах гомдолд заагаагүй боловч анхан шатны шүүхийн шийдвэрт хууль хэрэглээний, найруулгын, техникийн шинжтэй алдаа байвал өөрчлөлт оруулж, алдааг засна. Шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх, шийдвэр ойлгомжтой, тодорхой, биелүүлэх боломжтой байх шаардлагатай бөгөөд давж заалдах шатны шүүхийн энэ залруулгыг хуулийн шаардлагад нийцүүлсэн гэж үзнэ.

3.4. Хуулийн 167.1.4-т зааснаар анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож байгаа бол "хянавал" хэсэгт анхан шатны шүүх нотлох баримтыг хэрхэн буруу үнэлсэн, хуулийг хэрхэн буруу хэрэглэснийг тусгахын зэрэгцээ хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон хууль зүйн үндэслэл, нотлох баримтыг үнэлж дүгнэсэн байдал, хуулийг хэрхэн тайлбарлаж хэрэглэсэн тухайгаа тусгана.

3.5. Хуулийн 167.1.5-д зааснаар шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан магадлалд Хуулийн 168.1-т заасан аль үндэслэлээр буцааж байгаа, яагаад хүчингүй болгон дахин шийдвэрлүүлэх шаардлагатай гэж үзсэн үндэслэлээ тодорхой заана.

Магадлалд хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, анхан шатны шүүхийн процессын алдааг ямар ажиллагааг явуулсны эцэст хэргийг шийдвэрлэх талаар ойлгомжтой тусгаж болох боловч нотлох баримтыг хэрхэн үнэлэх, хэргийг хэрхэн шийдвэрлэхийг зааж чиглүүлсэн байдлаар тусгаж болохгүй.

#### Дөрөв. Магадлалын тогтоох хэсэг

4.1. Тогтоох хэсгийг бичихээс өмнө шийдвэрийг хэвээр үлдээсэн, өөрчлөлт оруулсан, хүчингүй болгох эрх олгосон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.1.1-167.1.5-д заасан холбогдох хэсгийг удирдлага болгоно.

Энэ хэсэгт давж заалдах шатны шүүх гаргасан шийдлээ тодорхой тусгана. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон бол энэ талаар зааж, давж заалдах гомдол гарахад төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг улсын орлогод хэвээр үлдээнэ. Хэрэв шийдвэрт өөрчлөлт оруулсан бол шийдвэрийн тогтоох хэсгийн аль заалтыг хэрхэн өөрчилсөн, үлдэх хэсэг нь хэвээр үлдэж байгаа эсэхийг заана. Харин шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн бол хэрэглэсэн материаллаг хуулийн заалтыг тусгана.

4.2. Шийдвэрт өөрчлөлт оруулах, шийдвэрийг хүчингүй болгож нэхэмжлэлийг эсвэл хэргийг хүчингүй болгосон тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг хэрхэн өөрчилж байгаагаа заахаас гадна давж заалдах гомдол гаргахад төлсөн улсын тэмдэгтийн хураамжийг хэрхэн шийдвэрлэснийг тогтоох хэсэгт тусгана. Магадлалд хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл, журмыг тодорхой заана.

4.3. Магадлалд шүүх бүрэлдэхүүн гарын үсгээ зурж, тамга дарж баталгаажуулсан байна.

-----oOo-----

Магадлалын ерөнхий загвар

МАГАДЛАЛ

2021 оны ....сарын ...

Дугаар

....хот

А-ын нэхэмжлэлтэй  
иргэний хэргийн тухай

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч.....даргалж, шүүгч ....., ..... нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн танхимд хийсэн давж заалдах шатны иргэний хэргийн (хаалттай, цахимаар) шүүх хуралдаанаар

Анхан шатны шүүхийн нэр, шийдвэрийн огноо, .. дугаар

Нэхэмжлэгч .....

Хариуцагч.....-д холбогдох

Нэхэмжлэлийн шаардлага, сөрөг нэхэмжлэл, гуравдагч этгээдийн бие даасан шаардлага:.....

хэргийг .....-ны гаргасан давж заалдах гомдлыг үндэслэн, шүүгч .....-ны илтгэснээр хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд: .....хэргийн оролцогч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга ..... нар оролцов.

ТОДОРХОЙЛОХ ХЭСЭГ:

1. Нэхэмжлэлийн агуулга:
  - 1.а. Нэхэмжлэлийн шаардлага,
  - 1.б. Нэхэмжлэлийн үндэслэл
2. Хариуцагчийн тайлбарын агуулга:
  - 2.а. хариуцагчийн татгалзал,
  - 2.б. хариуцагчийн татгалзлын үндэслэл
3. Сөрөг нэхэмжлэл, үндэслэл
4. Сөрөг нэхэмжлэлд гаргасан тайлбар, үндэслэл
5. Гуравдагч этгээдийн тайлбарын агуулга:
  - 5.а. Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийн тайлбарын агуулга
  - 5.б. Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн тайлбарын агуулга
6. Иргэдийн төлөөлөгч оролцсон бол түүний гаргасан дүгнэлт
7. Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулга.
8. Давж заалдах гомдлын агуулга:
  - 8.а. Шүүхийн шийдвэрийн аль хэсгийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа, түүний үндэслэл (бүхэлд нь эсхүл зарим хэсэг)
  - 8.б. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гомдол

8.в. хууль хэрэглээний талаарх

8.г. нотлох баримтын үнэлгээтэй холбоотой үндэслэл

8.д. техникийн шинжтэй алдаа

8.е. тооцооллын алдаа гэх мэт гомдлын үндэслэл бүрийг дугаарлан тусгана. (Ийнхүү тусгаснаар шүүх ямар гомдол гаргасан болохыг бүрэн тогтоохоос гадна гомдол үндэслэлтэй эсэхийг дүгнэх, гомдолд хариу өгөх боломжтой болно.)

#### ХЯНАВАЛ:

Эхлэл хэсэг: Хэргийг гомдлын хүрээнд эсвэл бүхэлд нь хянан хэлэлцсэн эсэхийг дурдаад, давж заалдах гомдлыг хангасан эсэхийг бичнэ.

1.Нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл, нотлох баримтын талаар дүгнэлт өгөх;

2.Хариуцагчийн татгалзал, үндэслэл, нотлох баримтын талаар дүгнэлт өгөх;

3.Гуравдагч этгээдийн (бие даасан шаардлага гаргасан, гаргаагүй) тайлбар, үндэслэл, нотлох баримтын талаар дүгнэлт өгөх;

4.Анхан шатны шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн талаарх дүгнэлт (маргааны үйл баримт, маргааны зүйл, шаардах эрх, хэрэглэвэл зохих хуулийг хэрэглэсэн, хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн эсэх, иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг хэрхэн үзсэн талаарх анхан шатны шүүхийн дүгнэлтийг давж заалдах шатны шүүх хэрхэн үзсэн тухай эрх зүйн дүгнэлт);

Шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцааж байгаа бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 168 дугаар зүйлийн 168.1.1-168.1.7 дахь хэсэгт заасан үндэслэл хэрхэн тогтоогдсон талаар, шийдвэрийг хэвээр үлдээх, шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа бол яагаад ийм шийдэлд хүрсэн хууль зүйн үндэслэлийг тусгасан байна;

5.Давж заалдах гомдолд өгсөн хариу буюу энэ талаарх шүүхийн дүгнэлт (давж заалдах гомдлын талаарх дүгнэлтийг энэ дарааллын дагуу эсвэл шаардлагатай гэж үзвэл давж заалдах шатны шүүхээс эрх зүйн дүгнэлт өгөх үед гомдолд дүгнэлт өгнө.)

#### ТОГТООХ ХЭСЭГ:

1.1.Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхих

1.2.Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаах

1.3.Анхан шатны шүүхийн шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгож, эвлэрлийг батлах (Жишээ нь: гэрлэлт цуцлах шаардлагыг хэвээр үлдээж, эд хөрөнгө болон хүүхдийн асрамжийн талаарх шаардлагын тухайд эвлэрснийг батлах зэрэг)

1.4.Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, зохигчдын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох

1.5.Анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах

2.Улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардлыг хэргийн оролцогчдод хуваарилах

3.Гомдол гаргах эрхийг дурдах

4.Шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулах.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны  
2021 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн  
29 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт

## ХЯНАЛТЫН ШАТНЫ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176 дугаар зүйлийн 176.3-т "...Тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, хяналтын гомдлын болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тусгана" гэж заасан нь хяналтын журмаар хэргийг хянан хэлэлцээд гаргах эрх зүйн акт буюу тогтоолд тусгах асуудлыг тогтоосон агуулгатай байна. Хяналтын журмаар гаргасан гомдлын дагуу хэргийг хянан хэлэлцээд гаргах тогтоол нь удиртгал, тодорхойлох, хянавал, тогтоох хэсгээс бүрдэнэ.

2. Хуулиар тусгайлан харьяалуулсан хэрэг, маргааныг хяналтын шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэх бол шийдвэр гаргах ба шийдвэрийн хэлбэр, бүтэц, агуулга Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

3. Хяналтын журмаар гаргасан гомдлын дагуу хэргийг хүлээж авсан хяналтын шатны шүүх:

а. танхимын нийт шүүгчдийн хуралдаан явуулж, гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсвэл хэлэлцүүлэхээс татгалзах тухай тогтоол гаргах (Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 173.5, 173.6, 173.7)

б. хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар хэргийг хянан хэлэлцээд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176 дугаар 176.2-т заасан тогтоолын аль нэгийг гаргана.

### Нэг. Тогтоолын удиртгал хэсэгт

1.1. Хуулийн 176.2, 176.3-т зааснаар хяналтын шатны шүүх тогтоолыг гаргасан он, сар өдөр, даргалагч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүх хуралдааны оролцогчдыг эцгийн/эхийн нэрийн эхний үсгийн хамт, хуулийн этгээд бол оноосон нэрийг нэрлэн зааж, хэний нэхэмжлэлтэй хэнд холбогдох, ямар маргаан, сөрөг нэхэмжлэл, бие даасан шаардлагыг хэлэлцсэн болохыг товч, ойлгомжтой илэрхийлсэн байна. Хэрэв шүүх хуралдааныг хуульд зааснаар хаалттай явуулсан бол энэ талаар заана.

### Хоёр. Тогтоолын тодорхойлох хэсэгт

2.1. Анхан болон давж заалдах шатны аль шүүхийн хэзээ гаргасан, ямар дугаартай шийдвэр, магадлал, түүний тогтоох хэсэгт баримталсан хуулийн заалт, нэхэмжлэлийг шийдвэрлэсэн байдал, хяналтын журмаар гаргасан хэргийн оролцогчийн гомдлын агуулга, эсрэг талын байр суурийг тус тус тусгана. Үүнд:

2.1.1. Эхлэл өгүүлбэр: хэнээс хэнд холбогдуулан ямар нэхэмжлэл гаргасан, хариуцагчийн татгалзал үндэслэлийг товч тусгана. Жишээ нь: Нэхэмжлэгч А-аас хариуцагч Б-д холбогдуулан худалдах-худалдан авах гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах нэхэмжлэл гаргасан.

2.1.2. Процессын түүх: анхан болон давж заалдах шатны шүүх хэргийг хэрхэн шийдвэрлэсэн талаар заана. Жишээ нь:

а.Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх ... өдрийн ... шийдвэрээр... үндэслэлээр нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн.

б.Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх ... өдрийн ... магадлалаар ... үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон.

в.Нэхэмжлэгчийн өмгөөлөгч ... өдөр хяналтын журмаар гомдол гаргасныг Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны ... тогтоолоор гомдлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

2.1.3.Хяналтын гомдлын үндэслэл: Хэргийн оролцогчийн гаргасан гомдлын үндэслэлийг агуулгаар нь дугаарлан тусгана.

2.1.4.Хэргийн бусад оролцогчийн байр суурь: Хяналтын журмаар гаргасан гомдлын талаар ямар байр суурьтай байгааг товч илэрхийлнэ.

#### Гурав.Тогтоолын хянавал хэсэгт

3.1.Нэгдсэн үр дүн буюу эхлэл хэсэг: Хяналтын журмаар гаргасан гомдлыг хэрхэн шийдвэрлэснийг тусгана. Жишээ нь, “Нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангах боломжгүй гэж үзэв.” гэх мэт.

3.2.Эрх зүйн үндэслэл:

3.2.1.Маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын хууль зүйн үндэслэл, түүний агуулгыг товч тусгана. Үүнд: нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл, хариуцагчийн татгалзал, түүний үндэслэл, шүүхээс тогтоосон маргааны үйл баримт, маргааны зүйл, шүүхийн хууль хэрэглэсэн байдалд эрх зүйн дүгнэлт өгнө.

3.2.2.Хяналтын журмаар гаргасан хэргийн оролцогчийн гомдол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2-т заасан аль үндэслэлд хамаарсныг зааж, анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн эсэх, шүүх хуулийг албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн нь үндэслэлтэй эсэх талаар зайлшгүй хийвэл зохих дүгнэлтийг тусгасан байна.

Хяналтын шатны шүүхийн бүрэн эрхэд хамаарахгүй асуудлаар гомдол гаргасан бол энэ талаар дүгнэлт өгөхгүй. Хяналтын журмаар гаргасан гомдлын үндэслэлээс хамаарч эрх зүйн үндэслэл хэсэг нь дараах дэд хэсгүүдтэй (бүгд эсхүл зарим нь) байж болно:

а.Тухайн хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой онолын болон харьцуулсан судалгааны хэсэг;

б.Тухайн асуудалтай холбоотой Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар байгаа эсэх, байгаа бол хэрхэн тайлбарласныг эшлэл заан тусгах;

в.Ижил төстэй хэргийг өмнө шийдвэрлэсэн байдал (эшлэл заан, дүгнэх байдлаар);

г.Анхан болон давж заалдах шатны шүүх холбогдох хуулийг хэрхэн зөрүүтэй байдлаар тайлбарласан;

д.Анхан, давж заалдах шатны шүүх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас яаж өөрөөр тайлбарлан хэрэглэсэн;

е.Тухайн хэрэг маргааныг ямар онолын үндэслэл, харьцуулсан судалгаа, Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг харгалзан үзэж, холбогдох хуулийг хэрхэн тайлбарлан хэрэглэж (хууль тайлбарлах аргаар), ямар эрх зүйн

эцсийн үр дагаварт хүрснээ тодорхойлж, түүнийг анхан болон давж заалдах шатны шүүх зөв тайлбарлан хэрэглэсэн эсэхэд дүгнэлт өгч шийдвэр, магадлалыг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэнэ.

Харин хэргийн оролцогчоос “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн” үндэслэлээр хяналтын журмаар гаргасан гомдлыг хянан хэлэлцсэн бол тогтоолын Хянавал хэсэгт тухайн процессын зөрчил нь ямар учраас шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэж үзэж байгааг тайлбарлаж, шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, анхан/давж заалдах шатны шүүхэд буцаах үндэслэлтэй болохыг дүгнэнэ.

Хянавал хэсгийн агуулга нь бүхэлдээ тогтоолын тодорхойлох хэсэгт заасан хэргийн оролцогчийн гаргасан гомдолд хариу өгөх байдлаар бичигдэнэ.

#### Дөрөв.Тогтоолын тогтоох хэсэгт

4.1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176 дугаар зүйлийн 176.2-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргасныг тусгана. Шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулах, шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох тохиолдолд баримталж буй хуулийн нэр, тухайн хуулийн зүйлд нэг ба түүнээс дээш хэсэг, заалт байгаа бол ямар хэсэг, заалтыг тодорхой заана.

4.2.Тогтоолыг шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргах бөгөөд илтгэгч шүүгч тогтоолын төслийг боловсруулж, шүүх бүрэлдэхүүн танилцан, санал нэг байгааг илэрхийлсний үндсэн дээр тогтоолыг гаргаж, шүүгчид гарын үсэг зурна. Шүүгч гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.

4.3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176 дугаар зүйлийн 176.4-т “Хяналтын шатны шүүхийн тогтоолд үг, үсэг, тооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан бол танхимын шүүх бүрэлдэхүүн хуралдаж, залруулга хийж болно.” гэж заасан. Энэ тохиолдолд хэргийн оролцогчийн хүсэлтээр эсвэл шүүхийн санаачлагаар шүүх бүрэлдэхүүн хуралдаж залруулга хийхдээ тогтоол гаргана. Хуулийн хүчин төгөлдөр болсон тогтоолд засвар оруулж байгаа тул залруулга хийсэн тогтоол нь хэлбэрийн хувьд удиртгал, тодорхойлох, хянавал, тогтоох хэсэгтэй байх боловч “хянавал” хэсэгт залруулга хийх болсон үндэслэл, залруулгыг хэрхэн хийх талаар тусгана.

4.4.Залруулга хийсэн тогтоолын дугаарыг өмнөх тогтоолын дугаарын ард А гэсэн тодотгол хийж, хэрэгт тогтоолын ард хавсаргана. Тогтоолд шүүгчид гарын үсэг зурна.

-----oOo-----

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны  
2021 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн  
29 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт

## ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр боловсруулахад дараах аргачлалыг баримтлахыг зөвлөж байна.

### Нэг. Шийдвэрийн удиртгал хэсэг

1.1. Удиртгал хэсэгт шүүхийн шийдвэрийг хэзээ, хаана, ямар шүүх гаргаж байгаа, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогчийг нэрлэн заана.

“Хэзээ” гэдэгт шүүх хуралдаан хэдий хугацаанд үргэлжилсэн гэдгээс үл хамаараад Монгол Улсын нэрийн өмнөөс шүүхийн шийдвэрийг танилцуулан сонгосон өдрийг ойлгож шийдвэрийг огноолно. Огноог “2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр” гэж бүтэн бичнэ.

“Хаана” гэдэгт шүүх хуралдааныг явуулж шүүх шийдвэрээ гаргасан газар, шүүх хуралдааны танхимыг хэлнэ. Шүүх хуралдааныг тодорхой шалтгаанаар өөр байранд хийсэн бол байршлыг заана. Шүүх хуралдаан хуульд зааснаар хаалттай явагдахаас бусад тохиолдолд нээлттэй явагддаг учир шүүх хуралдааныг хаалттай, эсхүл нээлттэй явуулсныг тусгана.

“Ямар шүүх” гэдэгт хэргийг хянан шийдвэрлэж буй шүүхийг Монгол Улсын шүүх байгуулах тухай хуулиар байгуулагдсан нэрээр тусгана.

“Шүүх бүрэлдэхүүн болон шүүгч” гэдэгт тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх бүрэлдэхүүний, эсхүл дангаар шийдвэрлэж буй шүүгчийн нэр байна. Шүүгчийн нэрийг эцэг (эхийн) нэрийн эхний үсгийн хамт бичнэ.

Хэргийн оролцогчид буюу нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдийг нэрлэн заана.

Нэхэмжлэгч, гуравдагч этгээд нь иргэн бол овоглодог эцгийн/эхийн нэр, өөрийн нэрийг иргэний үнэмлэх дээр бичигдсэнээр, гадаад улсын иргэн бол иргэний харьяаллыг, харьяалалгүй хүн бол нэрийг гадаад улсын иргэн болохыг гэрчлэх паспорт, паспортыг орлох баримт бичиг дээр Монгол Улсад оршин суух түр үнэмлэх дээр бичигдсэн англи үсгээр нь бичнэ. Гадаадын иргэний нэрийг дур мэдэн галиглаж, хөрвүүлэхгүй. Жишээ нь, БНХАУ-ын иргэний “Ni Run Gua” гэх нэрийг уг байдлаар нь бичнэ.

Хуулийн этгээд бол хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн нэрийг (төрийн албан ёсны монгол хэл, кирилл үсгээр), хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг албан ёсны товчлолоор, гадаадын хөрөнгө оруулалттай болон гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээд бол гадаад хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг тэр байдлаар нь үнэн зөв бичнэ. Жишээ нь: “...” ХХК, “...” УТҮГ, “...” ТӨААТҮГ, “...” банк ХХК, “...” LTD гэх мэт.

Нэхэмжлэгч, гуравдагч этгээдийг итгэмжлэлгүйгээр болон итгэмжлэлээр төлөөлж буй этгээдийн овог, нэрийг нь нэхэмжлэгч, гуравдагч этгээдээс тусдаа бичнэ.

Хариуцагч захиргааны байгууллагын нэрийг (улсын бүртгэлд бүртгэгдсэн байдлаар) зөв бичих, нийтийн эрх зүйн асуудлаар бие даан, өөрийн нэрийн өмнөөс дангаар захиргааны шийдвэр гаргах бүрэн эрх хуулиар олгогдсон албан тушаалтныг захиргааны байгууллага гэж үзэх учир албан тушаалын нэрийг зөв бичих нь зүйтэй. Жишээ нь, ... аймгийн (нийслэл, сум, дүүргийн) иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ... аймгийн (нийслэл, сум, дүүргийн) Засаг дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Батлан

хамгаалахын сайд, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Баянзүрх дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн боловсролын хяналтын улсын байцаагч гэх мэт.

Хариуцагч захиргааны байгууллагын албан тушаалтныг албан тушаалаар нь бичихээс бус тухайн хүний нэрийг бичих шаардлагагүй. Жишээ нь, хариуцагч Нийслэлийн Засаг дарга гэж бичихээс бус хариуцагч Нийслэлийн Засаг дарга Б.Бат гэхгүй. Харин шийдвэр нь тухайн албан тушаалтны нэрээр бичигддэг, өөрөөр хэлбэл шийдвэрийн албан бланкийг зөвхөн тухайн албан тушаалтан өөрийн нэрээр хэрэглэх эрхтэй бол албан тушаал болон тухайн хүний овгийн эхний үсэг, нэрийг хамт бичих нь зүйтэй. Жишээ нь, хариуцагч ... улсын хяналтын байцаагч Б.Болд гэх мэт.

1.2.Шүүхээр хэлэлцэж буй эрх зүйн маргааны агуулга буюу төрлийг заана.

1.3.Шүүх хуралдаанд оролцсон хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, шинжээч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын нэрийг овоглодог эцгийн/эхийн нэрийн эхний үсгийн хамт ("Н.Амарзаяа" гэж) бичнэ. Түүнчлэн, хэргийн оролцогч, шүүх хуралдааны оролцогч шүүх хуралдаанд цахимаар оролцсон бол тэр талаар тусгана. Мөн шүүх хуралдаанд оролцсон орчуулагч, хэлмэрчийн нэрийг нь бичнэ.

#### Хоёр.Шийдвэрийн тодорхойлох хэсэг

2.1.Эхлэл хэсэг: Тодорхойлох хэсгийн эхэнд хэнээс хэний эсрэг ямар нэхэмжлэлийн шаардлага гаргасныг нэхэмжлэгчийн тодорхойлсноор бичнэ. Жишээ нь: "Нэхэмжлэгч А нь Татварын ерөнхий газрын даргад холбогдуулан 2020 оны 07 дугаар сарын 13-ны өдрийн 10 дугаар тушаалыг хүчингүй болгуулж, ...албан тушаалд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин хөлс гаргуулах нэхэмжлэлийг гаргасан".

Хэрэв нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлсэн, багасгасан, эсхүл өөрчилсөн бол энэ талаар тусгах ба дээрх хэсэгт эцсийн байдлаар тодорхойлсныг бичнэ.

Нэхэмжлэлийн шаардлагаа тодорхойлох эрх зөвхөн нэхэмжлэгчид, түүнээс тусгайлан эрх олгосон итгэмжлэгдсэн төлөөлөгчид хадгалагдахыг (нэхэмжлэл гаргах эрх олгогдоогүй итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нэхэмжлэлийн шаардлагыг тодорхойлох эрхгүй) анхаарах хэрэгтэй.

2.2.Хэргийн нөхцөл байдлын талаарх хураангуй: Хэргийн үйл баримтыг товчлон тусгана. Тухайлбал, ямар үйл явдал болсон, хариуцагч хэзээ, ямар үндэслэлээр маргаан бүхий актыг гаргасан, тухайн актыг хэрхэн танилцуулсан гэх мэт.

2.3.Процессын түүх: Маргаан бүхий акт гарснаас хойш урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хэзээ, яаж явагдсан, ямар үр дүн гарсан, нэхэмжлэгч нэхэмжлэлийг хэзээ шүүхэд гаргасан талаар товч бичнэ.

2.4.Нэхэмжлэлийн үндэслэл: Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг буюу захиргааны үйл ажиллагааг (захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт, эсхүл захиргааны гэрээ гм.) хууль бус гэж маргаж буй хууль зүйн болон бодит үндэслэлийг нэг бүрчлэн (шаардлагатай бол дугаарлалт хэрэглэж) тодорхой бичнэ. Хэрэв нэхэмжлэгч хэд хэдэн нэхэмжлэлийн шаардлага гаргасан бол нэхэмжлэлийн төрөл тус бүрийн үндэслэлийг акт тус бүрээр бичнэ. Ингэхдээ нэхэмжлэлийг шууд хуулбарлах байдлаар бус харин агуулгаар нь, маргаж буй үндэслэлийг орхигдуулалгүйгээр, давхцуулахгүйгээр, логик дараалалтай, алдаагүй, цэгцтэй илэрхийлнэ.

2.5.Хариуцагчийн тайлбар: Нэхэмжлэлийн үндэслэлийг үгүйсгэж буй татгалзал, тайлбар бүрийг тодорхой тусгана.

Хэрэв хариуцагч захиргааны гэрээтэй холбоотой маргаанд сөрөг нэхэмжлэл гаргасан бол мөн тэдгээрийн үндэслэлийг нэхэмжлэлийн үндэслэлийг бичсэн шигээр тусгана.

2.6.Гуравдагч этгээдийн тайлбар: Нэхэмжлэлийг үгүйсгэж буй, хариуцагчийг хамгаалж буй үндэслэлийг тодорхой тусгана.

Хэрэв гуравдагч этгээд бие даасан шаардлага гаргасан бол шаардлагын агуулга, үндэслэлийг нэхэмжлэлийн үндэслэл бичсэн шигээр тусгана.

2.7.Хэргийн оролцогч нар нь шүүхэд гаргасан шаардлага, тайлбараа өөрчлөлгүйгээр шүүх хуралдаанд дэмжиж оролцсон бол агуулгыг нэгтгэж, харин шүүх хуралдаанд нэмж, өөрчилж гаргасан бол “шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа” гэж тусад нь давхардуулалгүйгээр тусгах нь зүйтэй.

2.8.Өмгөөлөгчийн тайлбарыг хэргийн оролцогчийн (үйлчлүүлэгчийнх нь) тайлбартай давхцуулахгүйгээр маргаж буй үйл баримт, нэхэмжлэлийн шаардлагын хууль зүйн үндэслэлд дүгнэлт хийсэн байдлыг бичнэ.

2.9.Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт: Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцсон бол дүгнэлтийн агуулгыг тусгана.

#### Гурав.Шийдвэрийн үндэслэх хэсэг

3.1.(Шаардлагатай бол нэхэмжлэлийг тодруулах): Хэрэв нэхэмжлэлийн шаардлага ойлгомжгүй, эсхүл хууль зүйн үг хэллэгээр илэрхийлээгүй тохиолдолд шүүх шаардлагатай гэж үзвэл нэхэмжлэлийн шаардлагын агуулга буюу нэхэмжлэгчийн хүсэл зоригийг хөндөхгүйгээр тодруулж, хууль зүйн хэллэгээр бичиж болно.

3.2.(Шаардлагатай бол шүүхийн шийдвэр гаргах болсон үндэслэлээ зөвтгөх): Жишээ нь, хэргийн оролцогчийг оролцуулалгүйгээр шүүх хуралдааныг явуулах болсон (зөвтгөх) үндэслэлийг заах гэх мэт.

3.3.Нэгдсэн үр дүн буюу эхлэл хэсэг: Үндэслэх хэсгийн эхэнд шүүх нэхэмжлэлийг хэрхэн шийдвэрлэснийг тусгана. Жишээ нь: “Нэхэмжлэл үндэслэлтэй /үндэслэлгүй байна.” гэх мэт.

3.4.Нэхэмжлэлийн үндэслэлт байдал: Энэ хэсэгт нэхэмжлэл үндэслэлтэй, эсхүл үндэслэлгүй гэж үзсэн бодит болон хууль зүйн үндэслэлийг дэлгэрэнгүй тайлбарлана. Тодруулбал, хэрэгт авагдсан, шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэслэл болгосон нотлох баримтыг үнэлж дүгнэсэн байдал, захиргааны актын хууль зүйн үндэслэл, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон бусад эрх зүйн хэм хэмжээ, тэдгээрийг хэргийн бодит нөхцөл байдалд хэрхэн тайлбарлаж хэрэглэсэн тухайгаа тусгана. Үндэслэлт байдал нь дараах гурван хэсгээс бүрдсэн байвал зохино. Үүнд:

3.4.1.Үйл баримтыг тогтоох хэсэг: Шүүх хариулт өгвөл маргааны зүйл буюу захиргааны үйл ажиллагааг (актыг) хууль бус гэж маргаж буй үндэслэл тус бүр, түүнийг үгүйсгэж буй хариуцагч, гуравдагч этгээдийн тайлбарын үндэслэлээр тодорхойлогдоно. Иймд нэхэмжлэгчийн маргаж буй үндэслэлийг (шийдвэрийн тодорхойлох хэсгийг дүгнэх байдлаар) нэг бүрчлэн бичнэ.

Маргааны зүйлийг буюу нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг тодорхойлсонтой холбогдуулан хэрэгт авагдсан нотлох баримтуудаар ямар үйл баримт тогтоогдож байгааг дүгнэх. Үүнд: хэргийн оролцогчдын өөрсдийн шаардлага, татгалзлынхаа үндэслэл болгон зааж буй нотлох баримтуудыг үнэлж, дүгнэсэн байдлаа бичнэ. Ингэхдээ тухайн нотлох баримтыг үнэлсэн, үнэлээгүй

үндэслэлийг, тухайлбал шаардлага хангасан, хангахгүй, эсхүл нотлох чадвартай, чадваргүй, хэрэгт хамааралтай, хамааралгүй, үйл баримтыг тогтооход ач холбогдолтой, холбогдолгүй байгааг, мөн нөгөө талууд тухайн баримтыг хэрхэн үгүйсгэж байгаа, түүнийг шүүх зөвшөөрч буй, эсхүл няцааж буй дүгнэлтээ бичнэ.

3.4.2. Эрх зүйн үндэслэлийг тодорхойлох хэсэг: Маргаан бүхий актын эрх зүйн үндэслэл, талуудын хэрэглэх ёстой гэж үзэж буй эрх зүйн үндэслэл, тухайн маргааныг шийдвэрлэхэд хэрэглэгдэх ёстой эрх зүйн үндэслэлийг тодорхойлно. Хэрэв өрсөлдөөнт хэм хэмжээ байгаа бол алийг нь сонгож хэрэглэх, сонгох болсон үндэслэлээ тайлбарлана (нарийвчилсан хууль, сүүлд батлагдсан хууль, эрх зүйн байдлыг дордуулсан юм уу дээрдүүлсэн хууль гэх зэргээр хууль хэрэглэх зарчмын дагуу).

3.4.3. Зүйлчлэл (субсумц) буюу эрх зүйн үр дагаврыг тодорхойлох хэсэг: Тогтоогдсон үйл баримтад холбогдох хуулийг хэрэглэж, эрх үр дагаврыг нь тодорхойлно. Жишээ нь, захиргааны актыг хууль бус (хүчингүй болгуулна) гэж маргаж байгаа тохиолдолд актын хууль зүйн үндэслэл нь зөв эсэх буюу тухайн тохиолдлыг шийдвэрлэхэд хэрэглэгдэх хууль зүйн үндэслэл мөн эсэх, актад заасан хуулийн урьдчилсан нөхцөл бодит байдалд бүрдсэн эсэхийг дүгнэх ба хэрэв үндэслэл болгосон хуулийн заалтад тодорхой бус ойлголт байгаа бол хариуцагч түүнийг зөв ойлгож, хэрэглэсэн эсэх, шүүх тухайн заалтыг хэрхэн тайлбарлаж байгаа (үгчилсэн, системчилсэн, зорилго, агуулгаар нь тайлбарлах зэрэг хууль тайлбарлах аргыг хэрэглэн), актын үндэслэл болсон хуулийн зохицуулалт нь захиргааны сонгох боломжид хамаарч байгаа бол хариуцагч сонгох боломжийг хэрэглэхдээ хуулийн хязгаарыг хэтрүүлсэн, буруу хэрэглэсэн, эсхүл өөрт олгосон эрх хэмжээг зорилгодоо нийцээгүй байдлаар ашигласны улмаас маргаан бүхий захиргааны акт (эсхүл татгалзсан шийдвэр, эс үйлдэхүй) хууль зөрчсөн эсэх, мөн захиргааны шийдвэр гаргах ажиллагааны журам зөрчигдсэн эсэх, тухайн зөрчил нь актын эрх зүйн үр дагаварт нөлөөлөх эсэхийг дүгнэнэ.

3.5. Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн талаарх үндэслэлээ тодорхой тусгана.

3.6. Эцэст нь маргаан бүхий захиргааны үйл ажиллагаа (шийдвэр) хууль бус болох нь тогтоогдсон тохиолдолд түүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн эсэхэд шүүхийн шийдвэр гарснаар зөрчигдсэн эрх нь сэргэх боломжтой эсэхэд (мөн анхаарах нь зүйтэй) дүгнэлт өгнө.

3.7. Үндэслэх хэсэг нь бүхэлдээ шийдвэрийн тодорхойлох хэсэгт заасан нэхэмжлэлийн шаардлага, гуравдагч этгээдийн бие даасан шаардлага болон хариуцагчийн сөрөг нэхэмжлэл, тэдгээрийн үндэслэлтэй уялдаа холбоотой буюу тэдгээрт хариу өгсөн шинжтэй байвал зохино. Түүнчлэн, хэргийн оролцогчдыг нэрлэн заахгүйгээр нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд гэсэн хэргийн оролцогчийн эрх зүйн байдлаар нь нэрлэвэл оновчтой ба харин хэд хэдэн нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд байгаа бол тэдгээрийг ялгах зорилгоор хүн, хуулийн этгээдийн (захиргааны байгууллагын) нэрийг тодорхой бичих нь зохистой.

3.8. Шийдвэрийн үндэслэх хэсгийг бичих тогтсон хэлбэр байх боломжгүй ч дараах загварыг жишээ болгож байна.

#### Дөрөв. Шийдвэрийн тогтоох хэсэг

4.1. Тогтоох хэсэг нь захиран тушаах хэлбэртэй байх ба шүүхээс гарч буй шийдвэрийн төрлийг тодорхойлсон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зүйл, хэсэг, заалтыг удирдлага болгож, холбогдох материаллаг хуулийн заалтыг баримтлан нэхэмжлэлийн шаардлагыг хэрхэн шийдвэрлэж буйг, улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн нөхөн төлөгдөх зардлыг хэрхэж буйг, шүүхийн

шийдвэрийг гүйцэтгүүлэх арга, журам, хугацааг хэрхэн шийдвэрлэснийг дараалуулан дугаарлаж бичин, төгсгөлд нь шүүхийн шийдвэрт гомдол гаргах арга журам, хугацааг заана. Шүүхийн шийдвэрт гомдол гаргах эсэхийг шүүх шийдвэрлэхгүй, хэргийн оролцогчид хуулиар олгогдсон эрх тул захиран тушаах хэлбэргүйгээр бичих ба энэ тохиолдолд дугаарлахгүй байж болно.

4.2. Шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг болон гуравдагч этгээд бие даасан шаардлага, хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргасан бол тэдгээр шаардлагыг шүүх хэрхэн шийдвэрлэсэн, шаардлагыг бүхэлд нь эсхүл заримыг нь хэрэгсэхгүй болгож байгаа бол хэнд холбогдох ямар шаардлагыг хэрхэж байгааг тодорхой заана.

4.3. Шийдвэрийн тогтоох хэсэгт нэхэмжлэлийн шаардлагыг эхлээд шийдвэрлэж, дараа нь гуравдагч этгээдийн бие даасан шаардлага, хариуцагчийн сөрөг шаардлагыг шийдвэрлэнэ. Бие даасан шаардлага, сөрөг шаардлагыг шийдвэрлэж буй байдлыг тогтоох хэсэгт нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэдэг аргаар тусгах ч нэхэмжлэлийн шаардлагатай харилцан тооцогдох, нэг актад холбогдох шаардлагыг шийдвэрлэхэд бие даасан шаардлага, сөрөг шаардлага шийдвэрлэгдэж болохоор байвал тогтоох хэсэгт нэг заалтад тусгах боломжтой.

4.4. Нэхэмжлэлд олон шаардлага байгаа бол, тэдгээрийн зарим хэсэгт бие даасан шаардлага, сөрөг нэхэмжлэл хамаарах бол тэдгээрийг бусад шаардлагаас тусад нь заалтаар шийдвэрлэх боломжтой.

Зарим шаардлагууд нь нэг төрлийнх биш ба тэдгээрийг шийдвэрлэхэд баримтлах хуулийн зүйл, заалт олон байгаа тохиолдолд бүх шаардлагыг шийдвэрийн тогтоох хэсгийн нэг заалтад багтааж шийдвэрлэж бичих нь шийдвэрийг ойлгомжгүй болгохыг анхаарна.

4.5. Нэхэмжлэлийн нэг төрлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож байгаа ба тэдгээрийн үндэслэл ижил бол шийдлийг тогтоох хэсгийн нэг заалтад бичнэ. Харин нэхэмжлэлийн зарим шаардлагыг хангасан, зарим шаардлагыг хангаагүй ба шаардлагыг хэрэгсэхгүй болгож байгаа үндэслэл өөр байгаа бол шийдлийг өөр заалтад тусгаж болно.

4.6. Үндэслэх хэсэгт маргааны үйл баримттай холбогдуулж хэрэглээгүй буюу дүгнээгүй хуулийн зүйл, хэсэг, заалтыг тогтоох хэсэгт баримтлахгүй.

4.7. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлд шүүхээс гарах шийдвэрийн төрлийг хуульчилсан тул тогтоох хэсгийн хэрэглэгдэх нэр томьёо, түүний агуулгыг хуулийн агуулга, нэр томьёонд нийцүүлнэ.

4.8. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.11-д заасан “хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулж захиргааны байгууллагаас дахин шинэ акт гаргах хүртэл захиргааны актыг 6 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж” шийдвэрлэсэн бол шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс энэ хугацаа тоологдохыг, шүүхээс тогтоосон энэ хугацаанд захиргааны байгууллага шинэ акт гаргаагүй бол уг маргаан бүхий акт хүчингүй болох үр дагавартай талаар тогтоох хэсэгт тусгана.

Зарчмын хувьд шийдвэрийн тогтоох хэсэгт процессын хуулийг удирдлага болгож, материаллаг хуулийг баримталдаг боловч зарим тохиолдолд процессын хуулийг тогтоох хэсэгт баримтлах тохиолдол байж болно. Тухайлбал, шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцэх явцад нэхэмжлэлийн зарим шаардлагыг хүлээн авахаас татгалзах, зарим шаардлагыг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхэд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтыг баримталж, мөн хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1, 109.2 дахь хэсгийг удирдлага болгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, тухайн шийдвэр (төрөл) гаргах үндэслэл болсон

процессын хуулийн зүйл, хэсэг, заалтыг удирдлага болгож, харин яагаад ийнхүү шийдвэрлэх болсон үндэслэл мөн процессын хуулийн зүйл, хэсэг, заалтыг баримтална.

4.9. Шүүхийн шийдвэрт шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурж, шүүхийн тамга дарж баталгаажуулна. Шүүхийн шийдвэрт шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зураагүй, эсхүл шүүх бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан нь дээд шатны шүүхээс шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах үндэслэл болохыг анхаарах хэрэгтэй.

4.10. Мөн тогтоох хэсэгт шүүхийн шийдвэр биелүүлэх арга журмыг заана.

-----oOo-----

Загвар 1 (Захиргааны хэрэг шийдвэрлэсэн шийдвэр)

НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН  
АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР

2021 оны ... сарын ...-ний өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

..... Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч ... даргалж, шүүгч ..., ... нарын бүрэлдэхүүнтэй, тус шүүхийн ... дугаар танхимд нээлттэй (хаалттай) хийсэн шүүх хуралдаанаар,

Нэхэмжлэгч: .....,

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: .....,

Хариуцагч: .....,

Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: .....,

Гуравдагч этгээд: .....,

Гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: ..... нарын хоорондын ..... маргааныг хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд: Нэхэмжлэгч, түүний өмгөөлөгч ....., хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч....., гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч....., иргэдийн төлөөлөгч ....., шүүх хуралдааны нарийн бичгийн дарга ..... нар оролцов.

ТОДОРХОЙЛОХ нь:

1.Нэхэмжлэгч ..... нь .....-д холбогдуулан “...”-аар маргаж байна.

2.Нэхэмжлэгч нь анх ... онд ..... даргын ... дугаар тушаалаар ... томилогдсон байна. ... оны ...-нд “...” үйл явдал болсон. Иймд хариуцагчаас нэхэмжлэгчийг ..... гэж үзэж маргаан бүхий актыг гаргажээ.

3.Нэхэмжлэгч нь маргаан бүхий актыг .... өдөр хүлээн авч, .... өдөр .....-д гомдол гаргасан боловч .... өдөр гомдлыг хангахаас татгалзсан хариу авсан.

..... оны ...-ны өдөр шүүх нэхэмжлэл гаргасан.

4.Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлдээ:

Маргаан бүхий акт нь дараах үндэслэлээр хууль бус. Үүнд:

1) ..... хуулийн .... зүйлийг зөрчсөн.

2) ..... хуулийн .... зүйлд заасан журмыг зөрчсөн тул хууль бус юм.

Уг актын улмаас миний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн тул хүчингүй болгож өгнө үү гэжээ.

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүх хуралдаанд гаргасан нэмэлт тайлбартаа: “...” гэв.

Нэхэмжлэгчийн өмгөөлөгч тайлбартаа: “ ... ” гэв.

5.Хариуцагч ... хариу тайлбартаа: “ ... ” гэв.

Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүх хуралдаанд гаргасан нэмэлт тайлбартаа: “ ... ” гэв.

6. Гуравдагч этгээд ... хариу тайлбартаа: “...” гэв.

7. Иргэдийн төлөөлөгч “ ... ” дүгнэлт гаргав.

ҮНДЭСЛЭХ нь:

1. Нэхэмжлэл үндэслэлтэй (үндэслэлгүй)-ийн зарим хэсэг үндэслэлтэй байна.

2. Нэхэмжлэгч дараах үндэслэлээр иргэн .... гэж маргасан байна. Үүнд:

1. ....

2. ....

3. .... гэх мэтээр.

3. Хэрэгт авагдсан ..... нотлох баримтаар нэхэмжлэгчийн ..... гэх үйл баримт тогтоогдсонгүй. Харин гуравдагч этгээдэд ..... байна.

4. .... хуулийн ...-д .... заажээ.

5. Иймд ..... нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн байна. Гэхдээ энэхүү үндэслэл нь маргаан бүхий актыг бүхэлд нь хууль бус гэж үзэх үндэслэл болохгүй тул ..... нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангах үндэслэлтэй.

Иймд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.1, 106.3.14, 109 дүгээр зүйлийн 109.2 дахь хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. .... хуулийн ..... дэх заалтыг тус тус баримтлан нэхэмжлэгч “ ... ” ХХК-ийн гаргасан “.....” шаардлагыг хэрэгсэхгүй болгож, үлдэх шаардлага болох ..... шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д зааснаар нэхэмжлэгчээс улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 70200 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 114.1-д заасны дагуу нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч шийдвэрийг эс зөвшөөрвөл гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ

....

Загвар 2 (Зөрчлийн хэргийг шийдвэрлэсэн шийдвэр)

НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН  
АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР

2021 оны ... сарын ...-ний өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

..... Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч ... даргалж, тус шүүхийн хуралдааны ... дугаар танхимд хийсэн нээлттэй шүүх хуралдаанаар,

Гомдол гаргагч: .....,

Хариуцагч: .....,

Гомдлын шаардлага: “.....” тухай шаардлага бүхий зөрчил хянан шийдвэрлэх захиргааны хэргийг хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд: гомдол гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч ... , өмгөөлөгч ... , хариуцагч ... , прокурор ... (шаардлагатай бол) шүүх хуралдааны нарийн бичгийн дарга ... нар оролцов.

ТОДОРХОЙЛОХ нь:

1.(Эхлэл хэсэг) Гомдол гаргагч ... нь “.....”-аар гомдол гаргасан.

2.(Хэргийн үйл баримт) Хариуцагч ... -ны өдөр иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу 20... оны ... дугаар сарын ... -ний өдөр ..... дүүргийн ... дүгээр хороо, .... худалдааны төвд байрлах ... цех, хөлдөөгчид худалдаалагдаж байгаа бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийж, “ ... ” үндэслэлээр Зөрчлийн тухай хуулийн ... дугаар зүйлийн ... -т заасан “ ... ” зөрчил гаргасан гэж үзээд “...” ХХК-д ... төгрөгөөр торгох шийтгэл ногдуулжээ.

3.(Процессын түүх) ...өдөр зөрчлийн хэргийг хэзээ нээсэн, ... ажиллагаа явуулсан, эсхүл хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна. Гомдол гаргагч .... - ний өдөр шүүхэд хандсан байна.

4.(Гомдлын үндэслэл) Гомдол гаргагч (итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч) Улсын байцаагчийн ... оны ... дугаар сарын ... -ний өдрийн ... тоот шийтгэлийн хуудсыг дараах үндэслэлээр хууль бус гэж үзэж байна. Үүнд:

4.1.Зөрчил үйлдээгүй...

4.2.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн ...

4.3.Зөрчлийн тухай хуулийн .... заалтыг буруу хэрэглэсэн ....” гэв.

5.(Хариуцагчийн тайлбар) Хариуцагч тайлбартаа: “...” гэв.

6.(Прокурорын дүгнэлт) Прокурор дүгнэлтдээ “...” гэв.

ҮНДЭСЛЭХ нь:

1.(Нэгдсэн үр дүн) Гомдол гаргагчийн (прокурорын) гомдол үндэслэлгүй (үндэслэлтэй) байна.

2.(Гомдлын үндэслэлт байдал):

2.1.(Зөрчлийг тогтоох хэсэг) Хэрэгт авагдсан .... нотлох баримтаар .... үйл баримт тогтоогдлоо.

2.2.Хариуцагч зөрчлийг хянан шалгахдаа Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны ... журмыг зөрчсөн/зөрчөөгүй.

2.3.Зөрчлийн тухай хуулийн ...-т заасан зөрчил нь ... бүрэлдэхүүнтэй байна.

2.4.Гомдол гаргагч нь ... зөрчлийг гаргасан (гаргаагүй). Иймд ..... дүүргийн ..... байцаагчийн ... тоот шийтгэлийн хуудас хууль бус (хууль ёсны) байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.1, 106.3.... дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

1..... хуулийн ... дугаар зүйлийн ..., Зөрчлийн тухай хуулийн ... дугаар зүйлийн ..., Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн ... дугаар зүйлийн ... дахь хэсэгт заасныг тус тус баримтлан ..... дүүрэг дэх ..... байцаагчийн 20... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... тоот шийтгэлийн хуудсыг хүчингүй болгож, ..... гомдлын шаардлагыг хангасугай. (“...” гомдлын шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай.)

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн... дугаар зүйлийн ...-д заасны дагуу гомдол гаргагчийн улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн ... төгрөгийг ...

3.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.2-т зааснаар гомдол гаргагч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар шийдвэрийг эс зөвшөөрвөл гардан авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ

....

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны  
2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн  
19 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт

## ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР/МАГАДЛАЛ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

### 1. Шийдвэр боловсруулах аргачлал

Давж заалдах шатны шүүх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1.4-т зааснаас бусад 112.1-д заасан тусгай журмаар шийдвэрлэгдэх маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэж, 106 дугаар зүйлд зааснаар Монгол Улсын нэрийн өмнөөс шийдвэр гаргахдаа захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр боловсруулах аргачлалыг баримтална.

Тухайн шийдвэрийн онцлогоос шалтгаалж тогтоох хэсэгт дараах зүйлийг тусгах нь зүйтэй. Үүнд: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1.1-д заасан улсын хэмжээний, эсхүл хоёр болон түүнээс дээш засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд үйлчлэх захиргааны хэм хэмжээний актыг мөн хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.8-д зааснаар хүчингүй болгосон, эсхүл хүчин төгөлдөр бусад тооцсон бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт Захиргааны ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 68.2-т заасны дагуу шийдвэр хүчин төгөлдөр болмогц хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхийг шүүхийн Тамгын газарт даалгасан заалтыг оруулна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1-д заасан анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн удирдлага болгох хуулийн заалтад 112.1 дэх хэсгийн холбогдох заалтыг заахаас гадна 112.1.5-д заасан маргааны тухайд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэхээр тусгайлан заасан хуулийн заалтыг нэмж тусгана. Энэ нь тухайн маргааныг ердийн захиргааны хэргээс ялгаатай, давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэж шийдвэр гаргаж байгааг ойлгомжтой болгоно. Тухайлбал, Банкны тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.3-д “Шүүх энэ хуулийн 75.1-т заасан гомдлыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112.1-т заасан тусгай журмаар хянан шийдвэрлэнэ” гэж заасан тул энэ төрлийн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг дараах байдлаар бичнэ. “Банкны тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.3, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1.5, 106 дугаар зүйлийн 106.3.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:” гэх мэт.

Мөн шийдвэрийн тогтоох хэсэгт гомдол гаргах хугацаа, журмыг ердийн хэргээс ялгаатай зохицуулсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.1-д заасныг тодорхой тусгах шаардлагатай.

### 2. Магадлал боловсруулах аргачлал

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх ердийн журмаар буюу Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.1-д зааснаар давж заалдах гомдол гарсан хэргийг хянан шийдвэрлэж, 113 дугаар зүйлийн 113.6, 119 дүгээр зүйлд заасны дагуу магадлал гаргахдаа мөн хуулийн 107 дугаар зүйлд заасан шүүхийн шийдвэрийн ерөнхий бүтцийг баримтлахаас гадна 119 дүгээр зүйлийн 119.1-д заасан анхан шатны шүүхийн шийдвэр, гомдлын агуулга, давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн үндэслэлийг дараах байдлаар тусгана.

## Нэг.Удиртгал хэсэг

1.1.Магадлалыг хэзээ, хаана, ямар шүүх гаргаж байгаа, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, давж заалдах шатны шүүх хуралдааны оролцогчийг нэрлэн заахаас гадна гомдол гаргасан хэргийн оролцогч болон аль байгууллагын шийдвэрийг хянан хэлэлцсэн, хэргийн индексийг тусгана. Шаардлагатай бол захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр боловсруулах аргачлалын холбогдох хэсгийг харна уу.

## Хоёр.Тодорхойлох хэсэг

Анхан шатны шүүхийн шийдвэрийн Тогтоох хэсгийн агуулга, давж заалдах гомдлын агуулгыг тусгана.

2.1.Эхлэл хэсэг: Хэнээс хэний эсрэг ямар нэхэмжлэлийн шаардлага гаргасныг бичнэ.

2.2.Процессын түүх: Анхан шатны шүүх нэхэмжлэлийг хэрхэн шийдвэрлэснийг буюу шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн агуулгыг бичнэ

2.3.Давж заалдах гомдлын агуулга: Хэргийн оролцогчоос гаргасан давж заалдах гомдлын үндэслэл бүрийг агуулгаар нь дугаарлан, тусгана.

2.4.Бусад оролцогчийн байр суурь: Хэргийн бусад оролцогч давж заалдах гомдлыг зөвшөөрч байгаа эсэхийг бичнэ.

## Гурав.Хянавал/үндэслэх хэсэг

3.1.Эхлэл хэсэг буюу хяналтын хүрээг заах: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.3-т зааснаар давж заалдах гомдлын хүрээнд хянасан, эсхүл хоёроос дээш оролцогч гомдол гаргасан юм уу нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гомдол гаргасан гэсэн үндэслэлээр хэргийг бүхэлд нь хянасан талаар тусгана. Мөн гомдлоор хязгаарлахгүйгээр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.4-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шийдвэрт нөлөөлсөн гэж үзсэн бол тэр талаар тусгана.

3.2.Нэгдсэн үр дүн: Давж заалдах шатны шүүхээс гомдлыг хэрхэн шийдвэрлэснийг тусгана. Жишээ нь: “Давж заалдах гомдлыг хангах үндэслэлгүй тул анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээв.” гэх мэт.

3.3.Эрх зүйн үндэслэл: Энэ хэсэг нь хэргийг гомдлын хүрээнд, эсхүл бүхэлд нь хянаж байгаагаас хамааран онцлог бүтэцтэй байна.

Хэргийг бүхэлд нь хянасан бол давж заалдах гомдлыг хангасан/зарим хэсгийг хангасан, эсвэл хангахгүй орхисон хэргийн бодит болон хууль зүйн үндэслэлийг тодорхой дэлгэрэнгүй тусгана. Ингэхдээ анхан шатны шүүх ямар нотлох баримтыг яаж буруу үнэлсэн, хуулийг хэрхэн буруу тайлбарлан хэрэглэсний учир гомдол үндэслэлтэй гэж дүгнэснээ, эсхүл яагаад үндэслэлгүй болохыг дэлгэрэнгүй тайлбарлана. Мөн гомдлын зарим хэсэг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд анхан шатны шүүхийн шийдвэрийн аль хэсгийг хууль зүйн болон бодит үндэслэлтэй, аль хэсгийг үндэслэлгүй буюу буруу гэж үзсэнээ тодорхой тусгана.

Харин гомдлын хүрээнд хянасан бол давж заалдах гомдлын үндэслэл бүрт (хэргийн үйл баримт болон хууль хэрэглээтэй холбоотой) хариу өгөх байдлаар гомдол үндэслэлтэй эсэхийг дүгнэнэ.

3.4.Давж заалдах гомдолд заагаагүй боловч анхан шатны шүүхийн шийдвэрт хууль хэрэглээний, найруулгын, техникийн шинжтэй алдаа байвал давж заалдах шатны шүүх өөрчлөлт оруулж, алдааг засах ба ийнхүү засахдаа эсрэг шийдэл хийж болохгүй. Учир нь шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх,

шийдвэр ойлгомжтой, тодорхой, биелүүлэх боломжтой байх шаардлагатай бөгөөд энэхүү шаардлагад нийцүүлсэн гэж үзнэ.

3.5. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д заасан аль үндэслэл хэрхэн тогтоогдож байгаа талаар тодорхой заана. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн алдаанд хамаарах тул гомдолд дурдсан эсэхээс үл хамаарч энэхүү магадлалыг гаргах тул гомдлыг хангасан эсэхийг заавал дурдах шаардлагагүй.

Харин шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан магадлалд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.3-т заасан аль үндэслэлээр буцааж байгааг тодорхой заана. Магадлалд анхан шатны шүүхийн процессын ямар алдаа гарсан, түүнийг яаж засах боломжтой талаар тусгахаас бус нотлох баримтыг хэрхэн үнэлэхийг, хэргийг хэрхэн шийдвэрлэхийг зааж чиглүүлэхгүй, маргааны үйл баримт, нотлох баримтыг эцэслэн дүгнэж болохгүй.

#### Дөрөв. Тогтоох хэсэг

4.1. Энэ хэсгийн эхэнд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн, өөрчлөлт оруулсан, хүчингүй болгох эрх олгосон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120-121 дүгээр зүйлийн холбогдох хэсгийг удирдлага болгоно.

4.2. Өөр хуульд заасны дагуу маргааныг шийдвэрлэсэн бол тухайн хуулийн эш татсан заалтыг хамт заана. Тухайлбал, Зөрчлийн хэргийг шийдвэрлээд гаргасан магадлалд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120.1, 121.1 дэх заалтын холбогдох хэсэгтэй хамт удирдлага болгоно. Мөн хуулийн 112 дугаар зүйлийн 112.1.4-т зааснаар Өмгөөллийн тухай хуулийн 7.7, 37.1-д заасан маргааныг шийдвэрлэж байгаа бол Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.6 дахь заалтын холбогдох хэсэгтэй хамт баримтална.

4.3. Тогтоох хэсэгт давж заалдах шатны шүүхээс гарсан шийдлээ тодорхой тусгана. Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон, эсхүл өөрчлөлт оруулсан бол шийдвэрийн Тогтоох хэсгийн аль заалтыг хэрхэн өөрчилсөн, үлдэх хэсэг нь хэвээр үлдэж байгаа эсэхийг заана. Хэрэв шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг шийдвэрлэсэн бол Хянавал хэсэгт хэрэглэсэн материаллаг хуулийн заалтыг заавал тусгана.

4.4. Анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилж хүчингүй болгосон тохиолдолд тухайн нэхэмжлэл хангагдсан эсэхтэй холбоотой шүүхийн шийдвэрт улсын тэмдэгтийн хураамжийг шийдвэрлэсэн хэсгийг хэрхэн өөрчилж байгаагаа заана.

4.5. Магадлалд хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл журмыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2-т заасан үндэслэл, хугацааг тодорхой заана.

Мөн хуулийн 112 дугаар зүйлийн 112.1.4-т заасан маргааныг шийдвэрлэсэн Магадлалын тогтоох хэсэгт Өмгөөллийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д заасан Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгохоос татгалзсан шийдвэрийг болон уг хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасан Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.6-д зааснаар хэвээр үлдээж, нэхэмжлэлийн шаардлагыг хангахгүй

орхисон, шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг хангасан, эсхүл шийдвэрийг хүчингүй болгож, маргааныг дахин шалгуулахаар шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтанд буцаасан байдлаа тодорхой тусгана.

-----o0o-----

Загвар 1  
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН  
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ

МАГАДЛАЛ

2021 оны ... сарын ...-ний өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

..... нэхэмжлэлтэй  
захиргааны хэргийн тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн давж заалдах журмаар хэргийг шийдвэрлэсэн

Шүүх бүрэлдэхүүн:...

Шүүх хуралдаан даргалсан шүүгч ...

Бүрэлдэхүүнд оролцсон шүүгч ...

Илтгэсэн шүүгч ...

Давж заалдах гомдол гаргасан хэргийн оролцогч:

Нэхэмжлэгч ...

Хариуцагч ...

Гуравдагч этгээд ...

Нэхэмжлэлийн шаардлага: ...

Гуравдагч этгээдийн бие даасан шаардлага:...

Давж заалдах гомдол гаргасан шүүхийн шийдвэр:...

Давж заалдах шатны шүүх хуралдааны оролцогчид:

Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч ...

Хариуцагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч ...

Гуравдагч этгээд, түүний төлөөлөгч, өмгөөлөгч ...

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга ...

Хэргийн индекс: ...

ТОДОРХОЙЛОХ нь:

1.Нэхэмжлэгч ... нь ..... газрын даргад холбогдуулан “.....”-аар маргасан байна.

2.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн .... -ний өдрийн ... дугаар шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.

3.Давж заалдах гомдлын агуулга: Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч дараах үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг эсэргүүцэж байна. Үүнд:

3.1.Анхан шатны шүүх ... нотлох баримтыг үнэлээгүйгээс хэргийн үйл баримтыг буруу дүгнэсэн.

3.2..... хуулийн .....-ийг буруу тайлбарлан хэрэглэсэн.... гэжээ.

4.Нэхэмжлэгч хариуцагчийн гомдлыг үгүйсгэж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хамгаалж байна.

#### ХЯНАВАЛ/ҮНДЭСЛЭХ нь:

1.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсэгт зааснаар анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах гомдлын хүрээнд хянав.

2.Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдол үндэслэлгүй тул анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээв.

3.Шүүх хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг дараах үндэслэлээр хангасангүй. Үүнд:

3.1.Шүүх хэргийн .... нотлох баримтыг ... зөв үнэлсэн, иймд “нотлох баримтыг буруу үнэлсэн” гэх хариуцагчийн давж заалдах гомдол үндэслэлгүй байна.

3.2.Анхан шатны шүүх Төрийн албаны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1.-д заасан “... удаа дараа (3 ба түүнээс дээш) албан үүргээ хангалтгүй биелүүлсэн” гэсэн хуулийн урьдчилсан нөхцөлийг хэргийн үйл баримтад холбогдуулан зөв тайлбарлан хэрэглэсэн байна. Учир нь,

Иймд анхан шатны шүүх хэргийн үйл баримтыг зөв дүгнэж, холбогдох хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн байх шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна... гэх мэт.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1, 120.3, 121 дүгээр зүйлийн 121.1, 121.2, 121.3 (эдгээр заалтын аль тохирох хэсгийг бичнэ.)-д заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1....Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн ... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, ...-ний гомдлыг хангахгүй орхисугай. (шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгосон бол баримталсан материаллаг хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтыг тодорхой зааж, шүүхэд гаргасан нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийг хангасан, эсхүл зарим хэсгийг хангаж, заримыг хэрэгсэхгүй болгосон, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон талаар тусгана.)

2.Нөхөн төлүүлэх шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийг хуваарилсан байдал, эд мөрийн баримтыг хэрхэх тухай бичнэ.

3.Магадлалыг эс зөвшөөрч гомдол гаргах журам, хугацааг заана.

ШҮҮГЧ

ШҮҮГЧ

ШҮҮГЧ

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны  
2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн  
29 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт

**ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ**

1. Хяналтын шатны шүүх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1 дэх хэсэгт заасан тусгай журмаар шийдвэрлэх маргааныг давж заалдах журмаар хянан шийдвэрлэж гаргасан тогтоолыг боловсруулахад Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал боловсруулах аргачлалыг баримтална. Тогтоолын тогтоох хэсгийн төгсгөлд улсын тэмдэгтийн хураамжийг хуваарилсан байдлыг тусгаж, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.2, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5.-д зааснаар хяналтын шатны тогтоол эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдана.

2. Хяналтын шатны шүүх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу хяналтын журмаар шийдвэрлэж гаргасан тогтоолыг боловсруулахад дараах аргачлалыг баримтална.

**Нэг. Тогтоолын удиртгал хэсэг**

1.1. Тогтоолыг хэзээ (тогтоолыг уншиж сонгосон буюу гаргасан өдөр), хаана (Улсын дээд шүүхийн аль хуралдааны танхимд), ямар шүүх (хяналтын шатны шүүхийн захиргааны хэргийн шүүх хуралдаан) гаргаж байгаа, шүүх бүрэлдэхүүний болон шүүх хуралдаанд оролцогч буюу нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын нэрийг тусгана.

1.2. Шүүхээр хянагдаж буй анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны шүүхийн магадлалын огноо, дугаарыг зааж тухайн шийдвэрийг хэний (хэргийн аль оролцогчийн) хяналтын журмаар гаргасан гомдлын дагуу хэлэлцэж байгааг болон тухайн гомдлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаас гарсан тогтоолын огноо, дугаарыг заана.

**Хоёр. Тогтоолын тодорхойлох хэсэг**

2.1. Эхлэл өгүүлбэр: Хэнээс хэний эсрэг ямар нэхэмжлэлийн шаардлага гаргасныг бичнэ. Жишээ нь, "Нэхэмжлэгч А-аас хариуцагч нийслэлийн Засаг даргад холбогдуулан Засаг даргын 2020 оны 01 сарын 01-ний өдрийн 01 дугаартай захирамжийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг гаргасан" гэх мэт.

2.2. Хэргийн нөхцөл байдал: Хэргийн үйл баримтыг товчлон (цаг хугацааны хувьд дараалуулах боломжтой бол дараалуулан) тусгана. Тухайлбал, нэхэмжлэгч А-д газар эзэмших эрх хэзээ, яаж үүссэн, ямар үйл ажиллагааг явуулсан, маргаан яагаад үүссэн, маргаан бүхий акт хэзээ ямар үндэслэлээр гарсан гэх мэт.

2.3. Процессын түүх: Анхан болон давж заалдах шатны шүүх хэргийг хэрхэн шийдвэрлэсэн талаар заана. Жишээ нь:

2.3.1. Нийслэл дэх захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийг .... үндэслэлээр хангаж шийдвэрлэсэн.

2.3.2.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх ... өдрийн магадлалаар ... үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон.

2.3.3.Нэхэмжлэгчийн өмгөөлөгч ... өдөр хяналтын журмаар гомдол гаргасныг Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны ... тогтоолоор гомдлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

2.4.Хяналтын гомдлын үндэслэл: Хэргийн оролцогчийн гаргасан хяналтын гомдлын үндэслэлийг заана. Жишээ нь: Нэхэмжлэгчээс давж заалдах шатны шүүхийн магадлалыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1. “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн” гэсэн үндэслэлээр гаргасан. Нэхэмжлэгч дараах үндэслэлээр давж заалдах шатны шүүх хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн тул хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж өгнө үү гэжээ. Үүнд:

1....

2....

3.... гэх зэргээр.

2.5.Хэргийн бусад оролцогчийн байр суурь: Хяналтын журмаар гаргасан гомдлын талаар хэргийн бусад оролцогч ямар байр суурьтай байгааг товч илэрхийлнэ. Жишээ нь: Хариуцагч нэхэмжлэгчийн гомдлыг үгүйсгэж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хамгаалж байна.

Гуравдагч этгээд тайлбар, гомдол гаргаагүй болно гэх мэт.

Гурав.Тогтоолын хянавал хэсэг

3.1.Нэгдсэн үр дүн буюу эхлэл хэсэг: Хяналтын шатны шүүхээс гомдлыг хэрхэн шийдвэрлэснийг энэ хэсэгт тусгана. Жишээ нь: “Нэхэмжлэгчийн хяналтын журмаар гаргасан гомдол үндэслэлтэй. Анхан болон давж заалдах шатны шүүх холбогдох хуулийн зохицуулалтыг зөрүүтэй тайлбарлан хэрэглэсэн байна.” гэх мэт.

3.2.Эрх зүйн үндэслэл: Хэргийн оролцогчоос хяналтын журмаар гаргасан гомдлыг хангасан/хангаагүй эрх зүйн үндэслэлийг буюу гомдол гаргагчийн маргаж буй хууль зүйн үндэслэлд дүгнэлт өгнө. Хяналтын журмаар гаргасан гомдлын үндэслэлээс хамаарч эрх зүйн үндэслэл хэсэг нь дараах дэд хэсгүүдтэй (бүгд эсхүл зарим нь) байж болно:

3.2.1.Тухайн хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой онолын болон харьцуулсан судалгааны хэсэг;

3.2.2.Тухайн асуудалтай холбоотой Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар байгаа эсэх, байгаа бол хэрхэн тайлбарласныг (эшлэл хийн) тусгах;

3.2.3.Ижил төстэй хэргийг өмнө шийдвэрлэсэн байдал (эшлэл заан, дүгнэх байдлаар);

3.2.4.Анхан болон давж заалдах шатны шүүх холбогдох хуулийг хэрхэн зөрүүтэй байдлаар тайлбарласан;

3.2.5.Анхан, давж заалдах шатны шүүх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас яаж өөрөөр тайлбарлан хэрэглэсэн;

3.2.6.Тухайн хэрэг маргааныг ямар онолын үндэслэл, харьцуулсан судалгаа, Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг харгалзан үзэж, холбогдох хуулийг хэрхэн тайлбарлан хэрэглэж (хууль тайлбарлах аргаар), ямар эрх зүйн эцсийн үр дагаварт хүрснээ тодорхойлж, түүнийг анхан болон давж заалдах шатны

шүүх яаж зөрүүтэй тайлбарлан хэрэглэсэн, аль нь зөв болохыг, эсхүл анхан, давж заалдах шатны шүүх Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарласан нь зөв/буруу болохыг дүгнэж, шийдвэр/магадлалыг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэнэ.

Харин хэргийн оролцогчоос “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн” үндэслэлээр хяналтын журмаар гаргасан гомдлыг хянан хэлэлцсэн бол тогтоолын Хянавал хэсэгт тухайн процессын зөрчил нь ямар учраас шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэж үзэж байгааг тайлбарлаж, шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, анхан/давж заалдах шатны шүүхэд буцаах үндэслэлтэй болохыг дүгнэнэ.

Хянавал хэсгийн агуулга нь бүхэлдээ тогтоолын тодорхойлох хэсэгт заасан хэргийн оролцогчийн гаргасан гомдолд хариу өгөх байдлаар бичигдэнэ.

#### Дөрөв.Тогтоолын тогтоох хэсэг

4.1.Энэ хэсэгт Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийг удирдлага болгон хэргийн оролцогчийн гомдлыг хангасан эсэхийг тодорхой заана. Тодруулбал:

а.Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий гэж үзвэл шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхино;

б.Давж заалдах шатны шүүх хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл магадлалыг бүхэлд нь юм уу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх юм уу өөрчилж, гомдлыг хангах;

в.Анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, холбогдох хуулийг баримтлан хэргийг болон нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож гомдлыг хангах;

г.Гомдол үндэслэлгүй боловч анхан/давж заалдах шатны шүүх хууль хэрэглээний алдаа гаргасан гэж үзвэл холбогдох хуулийг баримтлан шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулах;

д.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэж үзвэл шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан болон давж заалдах шатны шүүхэд буцаахаар заана.

Түүнчлэн улсын тэмдэгтийн хураамжийг хуваарилсан байдлыг тусгаж, төгсгөлд нь хяналтын шатны шүүхийн тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх ба уг тогтоол гомдол гаргахгүй болохыг дурдана.

-----oOo-----